

EPSON

WF-C529R Series

Хэрэглэгчийн Заавар

Агуулга

Энэхүү гарын авлагын тухай

Гарын авлагын танилцуулга.	6
Мэдээллийг хайх гарын авлагыг ашиглах.	6
Тэмдэг тэмдэглэгээ.	8
Энэхүү гарын авлагад ашигласан тодорхойлолт.	8
Үйлдлийн системийн лавлагаа.	8

Чухал заавар

Аюулгүй байдлын заавар.	10
Принтерийн зөвлөгөө, анхааруулга.	11
Принтерийг тохируулах зөвлөгөө болон анхааруулга.	11
Принтерийг ашиглах зөвлөгөө болон анхааруулга.	12
Принтерийг зөөвөрлөх, хадгалах зөвлөгөө болон анхааруулга.	12
Утасгүй холболт бүхий принтерийг ашиглах зөвлөгөө ба анхааруулга.	13
LCD дэлгэц ашиглах талаар өгөх зөвлөгөө, анхааруулга.	13
Администраторын нууц үгийн тухайд санамж.	13
Администраторын нууц үгийн өгөгдмөл утга.	13
Администраторын нууц үгийг тохируулаагүй байх.	14
Администраторын нууц үгийг өөрчлөх.	14
Администраторын нууц үгийг оруулахыг шаарддаг үйлдлүүд.	14
Администраторын нууц үгийг анхны утгад нь тохируулах.	15
Хувийн мэдээллээ хамгаалах.	15

Принтерийн үндсэн мэдээлэл

Эд ангийн нэр ба функцүүд.	16
Хяналтын самбар.	19
Үндсэн дэлгэцийн тохиргоо.	20
LCD дэлгэц дээр харагдах тэмдгүүд.	20
Үндсэн үйл ажиллагаа.	21
Тэмдэгтийг оруулах.	22
Хөдөлгөөнт дүрсийг харах.	23

Принтерийг бэлдэх

Цаасуудыг ачаалах.	25
-------------------------	----

Бэлэн байгаа цаас ба багтаамж.	25
Цаасан Кассет руу цаас ачаалах.	30
Арын Цаасны Дайз руу цаас ачаалах.	33
Дугтуй болон сануулга ачаалах.	35
Урт цаас ачаалах.	36
Цаасны төрлийн жагсаалт.	36
Тохиргоо-н цэсийн сонголтууд.	37
Принтерийн тохиргоо-н цэсийн сонголтууд.	37
Хэвлэлт тоолуур-н цэсийн сонголтууд.	45
Хангамжийн төлөв-н цэсийн сонголтууд.	45
Засвар үйлчилгээ-н цэсийн сонголтууд.	46
Хэл/Language-н цэсийн сонголтууд.	47
Принтерийн төлөв/Хэвлэлт-н цэсийн сонголтууд.	47
Баталгаажуулах төхөөрөмжийн төлөв-н цэсийн сонголтууд.	47
Epson Open Platform-ын мэдээлэл-н цэсийн сонголтууд.	47
Эрчим хүч хэмнэх.	48
Эрчим хүч хэмнэх — Хянах самбар.	48

Сүлжээний тохиргоо

Сүлжээний холболтын төрлүүд.	49
Ethernet-н холболт.	49
Wi-Fi холболт.	50
Wi-Fi Direct (Энгийн AP) холболт.	50
Компьютертай холбогдох.	51
Ухаалаг төхөөрөмжтэй холбох.	52
Утасгүй роутерээр дамжуулан ухаалаг төхөөрөмжтэй холбох.	52
Wi-Fi Direct ашиглан iPhone, iPad, iPod touch руу холбогдох.	52
Android төхөөрөмжүүд рүү Wi-Fi Direct-г ашиглан холбогдох.	55
iOS болон Android-с бусад төхөөрөмжийг Wi-Fi Direct-г ашиглан холбох.	58
Принтерээс Wi-Fi тохиргоог хийх.	61
SSID болон нууц үгээ оруулж Wi-Fi тохиргоог хийх.	61
Түлхэх товчийг тохируулж (WPS) Wi-Fi-н тохиргоог хийх.	63
PIN код оруулж Wi-Fi тохиргоог хийх (WPS).	64
Сүлжээний ахисан түвшний тохиргоо хийх.	65

Агуулга

Сүлжээний холболтын төлөвийг шалгах.	67
Сүлжээний тэмдэг.	67
Хянах самбараас Дэлгэрэнгүй сүлжээний мэдээллийг шалгах.	68
Сүлжээний холболтын тайланг хэвлэх.	68
Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэх.	74
Шинэ утасгүй роутерийг солих, нэмэх.	75
Компьютерт холбох аргыг өөрчлөх.	75
Хянах самбараас Сүлжээний тохиргоог Ethernet болгон өөрчлөх.	76
Wi-Fi Direct (Энгийн AP) тохиргоог өөрчлөх.	76
Хянах самбараас Wi-Fi-г салгах.	77
Хянах самбараас Wi-Fi Direct (Энгийн AP) холболтыг салгах.	78
Принтерийн хянах самбараас Сүлжээний тохиргоог сэргээх.	79

Хэвлэх

Windows дээрх принтерийн драйвераас хэвлэх.	81
Принтерийн драйверт хандах.	81
Принтерийн үндсэн мэдээлэл.	82
2-талаар хэвлэх.	83
Нэг хуудсан дээр хэд хэдэн хуудсыг хэвлэх.	84
Хуудсыг дараалалтай хэвлэх болон багцлах (Хэвлэх дарааллыг хөрвүүлэх).	85
Жижигрүүлсэн эсвэл томруулсан баримт бичгийг хэвлэх.	85
Томруулахын тулд олон хуудсан дээр нэг зураг хэвлэх (Зурагт хуудас хийх).	86
Толгой ба доод хэсгийг хэвлэх.	92
Хуулбарлалтын эсрэг хээ хэвлэх.	93
Нууц үгийн хамгаалалттай файлуудыг хэвлэх.	94
Олон файлыг хамт хэвлэх.	94
Нийтлэг өнгө принтерийн онцлогийг ашиглан хэвлэх.	95
Принтерийн өнгийг тохируулах.	96
Нарийн зураасыг тодруулж хэвлэх.	97
Бар кодыг тодорхой хэвлэх.	97
Хэвлэхийг цуцлах.	98
Принтерийн драйверын цэсийн зүйлс.	98
Windows дээрх PostScript принтерийн драйвераас хэвлэх.	101
PostScript принтерийн драйверын цэсийн зүйлс.	102
Хэвлэхийг цуцлах.	103
Mac OS дээрх принтерийн драйвераас хэвлэх.	104

Хэвлэлтийн үндсэн мэдээлэл.	104
2-талаар хэвлэх.	105
Нэг хуудсан дээр хэд хэдэн хуудсыг хэвлэх.	106
Хуудсыг дараалалтай хэвлэх болон багцлах (Хэвлэх дарааллыг хөрвүүлэх).	107
Жижигрүүлсэн эсвэл томруулсан баримт бичгийг хэвлэх.	107
Принтерийн өнгийг тохируулах.	108
Хэвлэхийг цуцлах.	109
Принтерийн драйверын цэсийн зүйлс.	109
Mac OS принтерийн драйверт ашиглалтын тохиргоог хийх.	111
Mac OS дээрх PostScript принтерийн драйвераас хэвлэх.	111
PostScript принтерийн драйверын цэсийн зүйлс.	112
Хэвлэхийг цуцлах.	114
Ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх.	114
Epson iPrint ашиглах.	114
Epson хэвлэхийг идэвхжүүлэгчийг ашиглах.	116
AirPrint ашиглах.	117
Ачаалж буй ажлыг цуцлах.	117

**Бэхээр Хангах Нэгжүүд ба
бусад зарцуулагдах зүйлсийг
солих**

Үлдсэн бэх болон Арчилгааны хайрцгийн төлөвийг шалгах.	118
Үлдсэн бэх болон Арчилгааны хайрцгийн төлөвийг шалгах — Хянах самбар.	118
Үлдсэн бэх болон Засвар үйлчилгээний хайрцгийн төлөвийг шалгах — Windows.	118
Үлдсэн бэх болон Арчилгааны хайрцгийн төлөвийг шалгах — Mac OS.	118
Бэх Нийлүүлэх Нэгж Код.	119
Бэх Нийлүүлэх Нэгж Ашиглалтын урьдчилсан санамж.	119
Бэхээр Хангах Нэгжүүд солих.	121
Арчилгааны хайрцгийн код.	121
Засварын хайрцгийг ашиглах санамжууд.	121
Арчилгааны хайрцгийг солих.	122
Түр зуур хар хороор хэвлэх.	122
Түр зуур хар хороор хэвлэх — Хяналтын самбар.	122
Түр хугацаанд хар хороор хэвлэх — Windows.	123

Хар хор дуусаж эхлэнгүүт хэмнэх (Зөвхөн Windows).....	124
---	-----

Принтерийг хадгалах

Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх.....	125
Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Хяналтын самбар.....	125
Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Windows.....	126
Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх — Mac OS.....	126
Шугамтай зураасуудыг тэгшлэх.....	127
Цаасны зам дахь бэхний өнгөрийг цэвэрлэх.....	127

Сүлжээний үйлчилгээ болон программын мэдээлэл

Принтерийн үйлдлийг тохируулах програм (Web Config).....	129
Вэб тохируулгыг вэб хөтөч дээр ажиллуулах.....	129
Web Config-г Windows дээр ажиллуулах.....	130
Web Config-г Mac OS дээр ажиллуулах.....	130
Вэб хуудас хэвлэх программ (E-Web Print) (зөвхөн Windows -д зориулж).....	130
Олон төхөөрөмжинд тохиргоо хийх програм (EpsonNet Config).....	131
Програм хангамжийн шинэчлэлийн хэрэгслүүд (EPSON Software Updater).....	131
Сүүлийн үеийн програмуудыг суулгах.....	132
PostScript принтерийн драйвер суурилуулах.....	134
PostScript принтерийн драйвер суурилуулах — Windows.....	134
PostScript принтерийн драйвер суурилуулах — Mac OS.....	134
Epson универсаль принтерийн драйверыг суурилуулах (зөвхөн Windows-д зориулсан).....	135
Программ хангамжийг суулгах.....	135
Програмуудыг арилгах — Windows.....	135
Програм суулгах- Mac OS.....	136
Сүлжээний сервис ашиглан хэвлэх.....	137

Асуудлыг шийдэх

Принтерийн төлөвийг шалгах.....	138
LCD дэлгэц дээрх зурвасыг шалгах.....	138

Принтерийн төлөвийг шалгах — Windows.....	139
Принтерийн төлөвийг шалгах — Mac OS.....	139
Программ хангамжийн төлөвийг шалгах.....	140
Бөглөрсөн цаасыг салгах.....	140
Цаас зөв татагдахгүй байна.....	140
Цаас гацалт.....	141
Цаас хазайж татагдаж байвал.....	141
Нэг дор хэд хэдэн хуудас татагдвал.....	141
Сонголтын чанартай цаасан хуурцгийн хэсгээс цаас татагдахгүй байх.....	141
Цаас дууссан алдаа гарвал.....	142
Тэжээл ба хяналтын самбарын асуудал.....	142
Тэжээл асахгүй байна.....	142
Тэжээл унтрахгүй байна.....	142
Тэжээл автоматаар унтарна.....	142
LCD дэлгэц бараан болох.....	142
Хянах самбараас ашиглах боломжгүй.....	142
Компьютероос хэвлэх боломжгүй.....	143
Холболт шалгах (USB).....	143
Холболт шалгах (Сүлжээ).....	143
Программ хангамж ба өгөгдлийг шалгах.....	144
Компьютероос принтерийн төлөвийг шалгах (Windows).....	146
Компьютероос принтерийн төлөвийг шалгах (Mac OS).....	147
Би техник хангамжийн хуучин хувилбарыг ашиглаж байгаа гэж нууц үгийг тохируулсан үед ажлыг хэвлэх боломжгүй.....	147
Сүлжээний тохиргоо хийж чадахгүй бол.....	148
Хэдийгээр сүлжээний тохиргоонд асуудал гараагүй ч төхөөрөмжөөс холбогдох боломжгүй байх.....	148
Принтертэй холбоотой SSID-г шалгах.....	150
Компьютерын SSID-г шалгах.....	151
iPhone эсвэл iPad-с хэвлэх боломжгүй.....	152
Хэвлэмэл материалын асуудал.....	152
Хэвлэлтийн чанарыг тохируулах.....	152
Цаас тус бүрийн хэвлэлтийн чанарыг тохируулах.....	153
Хэвлэгдсэн зүйл зурагдсан эсвэл өнгөгүй байх.....	154
Судал эсвэл санаандгүй өнгүүд харагдана.....	155
Ойролцоогоор 3.3 см-ийн зайтай өнгөт судлууд гарч ирнэ.....	155
Бүдэг хэвлэлт, Босоо судал, Далий.....	156
Хэвлэлтийн чанар муу байвал.....	156
Цаас балархайтах буюу үнгэгдсэн байвал.....	157

Агуулга

Автомат 2 талт хэвлэлтийн үед цаас балархайтсан бол.	158
Хэвлэсэн фото зураг наалдамхай байвал	158
Зураг юмуу фото зураг хэвийн бус өнгөөр хэвлэгдэж байвал.	159
Хэвлэмэл материалын байрлал, хэмжээ, хүрээ буруу байх.	159
Хэвлэсэн тэмдэгт буруу, ташаа байх.	159
Хэвлэсэн зураг буруу харах.	160
Хэвлэлтийн Мозайк маягийн хээ угалз. ...	160
Санаандгүй 2 талаар хэвлэх.	160
Хэвлэмэл материалын асуудал шийдэгдэхгүй байх.	160
Хэвлэх бусад асуудал.	160
Хэт удаан хэвлэх.	160
Үргэлжилсэн Хэвлэлтийн Үед Хэвлэлт Удаашрах.	161
Mac OS X v10.6.8 дээр ажилладаг компьютероос хэвлэх ажлыг цуцлах боломжгүй.	161
PostScript принтерийн драйверын асуудал.	161
PostScript принтерийн драйвер ашиглаж байгаа үед принтер хэвлэхгүй байх.	162
PostScript принтерийн драйвер ашиглаж байгаа үед принтер зөв хэвлэдэггүй.	162
PostScript принтерийн драйвер ашиглаж байгаа үед принтерийн чанар муу байна.	162
PostScript принтерийн драйвер ашиглаж байгаа үед принтер хэт удаан байх.	162
Бусад асуудал.	162
Принтерт хүрэхэд бага зэргийн тог цохиж байна.	162
Ажиллагаа чанга дуутай байвал.	163
Нууц үгээ мартсан бол.	163
Программ хангамжийг Firewall хаах (Windows-т зөвхөн).	163

Хавсралт

Техникийн тодорхойлолт.	164
Принтерийн үзүүлэлт.	164
Интерфэйсийн үзүүлэлт.	165
Сүлжээний функцийн жагсаалт.	165
Wi-Fi-ийн үзүүлэлтүүд.	166
Ethernet үзүүлэлт.	166
Аюулгүй байдлын протокол.	166
3-р түвшний PostScript-ийн таарамж. ...	167
Дэмждэг гуравдагч талын үйлчилгээ. ...	167

Хэмжээс.	167
Цахилгааны Үзүүлэлтүүд.	167
Орчны үзүүлэлт.	168
Суурилуулах байршил ба зай.	168
Системийн шаардлага.	170
Үсгийн хэвний мэдээлэл.	170
PostScript-д байгаа үсгийн хэвүүд.	170
PCL -ийн боломжтой үсгийн хэвүүд (URW).	171
Тэмдгүүдийн багцын жагсаалт.	173
Сонголтын чанартай хэсгүүдийг суурилуулах.	176
Сонголтын чанартай цаасан хуурцгийн хэсгийн код.	176
Сонголтын чанартай цаасны хайрцгийн хэсгүүдийг суурилуулах.	176
Хууль журмын мэдээлэл.	180
Стандарт ба зөвшөөрөл.	180
German Blue Angel.	182
Хуулбарлахад тавигдах хязгаарлалт. ...	182
Принтерийг зөөвөрлөх ба байршуулах. ...	182
Зохиогчийн эрх.	186
Худалдааны тэмдэг.	187
Хаанаас тусламж авах вэ.	188
Техник туслалцааны вэбсайт.	188
Epson-н тусламжтай холбогдох.	189

Энэхүү гарын авлагын тухай

Гарын авлагын танилцуулга

Дараах гарын авлагууд нь таны Epson принтерт дагалдаж ирсэн байгаа. Гарын авлагаас гадна принтер эсвэл Epson-ы программ хангамжаас янз бүрийн төрлийн тусламж мэдээллийг шалгана уу.

- ☐ Чухал Аюулгүй байдлын Заавар (хэвлэмэл гарын авлага)
Принтерийг аюулгүй ажиллуулах зааварчилгаагаар хангана.
- ☐ Энд эхэл (хэвлэмэл гарын авлага)
Принтерийг тохируулж програм хангамжийг суулгах мэдээллээр хангана.
- ☐ Хэрэглэгчийн Заавар (дижитал гарын авлага)
Энэхүү гарын авлага. Принтерийг сүлжээнд ашиглах тухай ерөнхий мэдээлэл ба зааврыг принтерийг сүлжээнд ашиглан асуудлыг шийдэх үед өгнө.
- ☐ Администраторын Заавар (дижитал гарын авлага)
Э-мэйл мэдэгдлийн онцлог зэрэг удирдлага, принтерийн тохиргооны мэдээллийг сүлжээний администраторуудад түгээдэг.

Та дээрх гарын авлагуудын хамгийн сүүлийн хувилбарыг даараах аргуудаар олж авах боломжтой.

- ☐ Хэвлэмэл гарын авлага
Epson Европ вэбсайтад <http://www.epson.eu/Support> хаягаар, эсвэл Epson дэлхий дахины вэбсайтад <http://support.epson.net/> хаягаар зочлоорой.
- ☐ Дижитал гарын авлага
Компьютер дээрээ EPSON Software Updater-ийг эхлүүл. EPSON Software Updater нь Epson програм хангамж болон дижитал гарын авлагын боломжит шинэчлэлүүдийг шалгаж, хамгийн сүүлийн хувилбарыг татах боломжийг олгоно.

Холбогдох мэдээлэл

- ➔ [131 хуудас дээрх "Програм хангамжийн шинэчлэлийн хэрэгслүүд \(EPSON Software Updater\)"](#)


Мэдээллийг хайх гарын авлагыг ашиглах

PDF гарын авлага түлхүүр үгээр хайж байгаа мэдээллийг хайх боломж олгох ба мөн номын хавчуурга ашиглан тодорхой хэсэгт шууд очих боломжтой. Та мөн зөвхөн хэрэгтэй хуудсуудаа хэвлэх боломжтой. Энэ хэсэг нь таны компьютер дээр Adobe Reader X ашиглан нээгдсэн PDF гарын авлагыг хэрхэн ашиглахыг тайлбарлана.

Энэхүү гарын авлагын тухай

Түлхүүр үгээр хайх


Засах > Нарийн хайлт товш.Хайх цонхоос хайхыг хүсэж байгаа мэдээллийнхээ түлхүүр үг (бичвэр)-ийг оруулж, дараа нь **Хайх** товш.Хайлт жагсаалт хэлбэрээр харагдана.Харуулсан хайлтын нэгийг товшиж тухайн хуудас руу үсэр.



Номын хавчуургаас шууд үсрэх

Нэр дээр товшиж тухайн хуудас руу үсэр.+ эсвэл > товшиж тухайн хэсгийн доод түвшний нэрийг хар.Өмнөх хуудас руу буцахын тулд гар дээр байгаа дараах үйлдлийг гүйцэтгэ.


- ☐ Windows: **Alt**-г удаан дарж, дараа нь ← дар.
- ☐ Mac OS: Командын түлхүүрийг барьж, ← дар.



Зөвхөн хэрэгтэй хуудсаа хэвлэ

Та зөвхөн хэрэгтэй хуудсуудаа гаргаж хэвлэх боломжтой.**Хэвлэх** дээр **Файл** цэсээс товшиж, **ХуудсуудХэвлэх хуудсууд** дээрээс хэвлэхийг хүссэн хуудсуудыг тодорхой зааж өгнө үү.

- ☐ Цуврал хуудсуудыг тодорхой зааж өгөхийн тулд эхлэл ба төгсгөл хуудасны хоорондох зайг оруул.
Жишээ: 20 – 25
- ☐ Цувралд байхгүй хуудсуудыг тодорхой зааж өгөхийн тулд таслалаар хуудсуудыг заагла.
Жишээ: 5, 10, 15



Тэмдэг тэмдэглэгээ



Болгоомжтой:

Биедээ гэмтэл авахгүйн тулд анхааралтай дагах ёстой заавар.



Чухал:

Принтертээ гэмтэл учруулахаас сэргийлэхийн тулд дагах ёстой заавар.

Тэмдэглэл:

Нэмэлт, лавлагааны чанартай мэдээллээр хангана.

Холбогдох мэдээлэл

➔ Холбогдох хэсэг рүү хөтлөх холбоос.

Энэхүү гарын авлагад ашигласан тодорхойлолт

- ☐ Принтерийн драйверын дэлгэцийн дүрслэл Windows 10 эсвэл macOS High Sierra-с гарсан. Дэлгэц дээр дүрсэлсэн зүйлс загвар, нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байдаг.
- ☐ Энэхүү гарын авлагад ашигласан зураглал зөвхөн жишээний үүрэгтэй. Загвараас шалтгаалан бага зэргийн ялгаа байж болох ч, ажиллуулах арга ажиллагаа адил байна.
- ☐ LCD дээрх цэсний зүйлийн заримын дэлгэц загвар, тохиргооноос шалтгаалж өөр өөр байна.
- ☐ Та зориулалтын программ ашиглан QR кодыг уншиж болно.

Үйлдлийн системийн лавлагаа

Windows

Энэхүү гарын авлагад дурдсан "Windows 10", "Windows 8.1", "Windows 8", "Windows 7", "Windows Vista", "Windows XP", "Windows Server 2016", "Windows Server 2012 R2", "Windows Server 2012", "Windows Server 2008 R2", "Windows Server 2008", "Windows Server 2003 R2", "Windows Server 2003" зэрэг нэршил нь дараах үйлдлийн системийг илэрхийлсэн болно. Түүнчлэн, "Windows" нь бүх хувилбарыг илэрхийлнэ.

- ☐ Microsoft® Windows® 10 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows® 8.1 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows® 8 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows® 7 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Vista® үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows® XP үйлдлийн систем

Энэхүү гарын авлагын тухай

- ☐ Microsoft® Windows® XP Professional x64 Edition үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2016 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2012 R2 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2012 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2008 R2 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2008 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2003 R2 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2003 үйлдлийн систем

Mac OS

Энэ гарын авлагад, "Mac OS" нь macOS High Sierra, macOS Sierra, OS X El Capitan, OS X Yosemite, OS X Mavericks, OS X Mountain Lion, Mac OS X v10.7.x болон Mac OS X v10.6.8 зэргийг илэрхийлнэ.

Чухал заавар


Аюулгүй байдлын заавар

Энэхүү принтерийг аюулгүй ашиглахын тулд дараах зааврыг уншиж даган мөрдөнө үү. Энэхүү гарын авлагыг ирээдүйд ашиглахын тулд хадгална уу. Түүнчлэн, энэхүү принтер дээр тэмдэглэсэн бүх анхааруулга, зааврыг мөрдөж биелүүлнэ үү.

- ☐ Таны принтерт хэрэгдэгдэж байгаа зарим таних тэмдгүүд нь принтерийг зөв, аюулгүй ашиглахад зориулагдсан байдаг. Уг таних тэмдгүүдийн утга учрын талаар мэдэхийн тулд дараах веб сайтад зочилно уу.
<http://support.epson.net/symbols>
- ☐ Энэхүү принтертэй цуг ирсэн тэжээлийн утсыг зөвхөн ашиглаж, аливаа бусад тоног төхөөрөмжийн тэжээлийн утсыг ашиглахаас татгалзана уу. Энэхүү принтерт бусад төхөөрөмжийн цахилгаан утсыг ашиглах, эсвэл цуг ирсэн тэжээлийн утсыг өөр бусад тоног төхөөрөмж дээр ашиглах нь гал түймэр, цахилгаанд цохиулах аюулгүй бий болгоно.
- ☐ АС тэжээлийн утас дотоодын аюулгүй ажиллагааны зохих стандартад нийцэж байгаа эсэхийг шалгана уу.
- ☐ Принтерийн гарын авлага дээр тодорхой зааснаас бусад тохиолдолд тэжээлийн утас, залгуур, принтерийг өөрийн мэдлээр хэзээ ч бүү задалж, өөрчлөн, засахыг оролдох хэрэггүй.
- ☐ Дараах тохиолдолд принтерийг тэжээлээс салгаж, ур чадвар бүхий үйлчилгээний ажилтнаар засвар үйлчилгээ хийлгэнэ үү:
Тэжээлийн утас, эсвэл залгуур эвдэрсэн; принтерт шингэн нэвтэрсэн; принтерийг унагаасан, эсвэл гаднах хайрцаг эвдэрсэн; принтер ердийн байдлаар ажиллахгүй эсвэл ажиллагаанд нь онцгой өөрчлөлт орсон. Ашиглалтын зааварт ороогүй хяналтын үйл ажиллагааг тохируулж болохгүй.
- ☐ Залгуурыг хялбар холбож болохоор байрлалд ханын залгуурт ойр принтерийг байрлуулна.
- ☐ Их хэмжээний тоос шороо, ус, халууны эх үүсвэр бүхий гадаа байрлалд принтерийг тавихгүй байх, эсвэл цахилгаанд цохиулах, чичиргээнд өртөх өндөр температур, чийгтэй газар тавьж болохгүй.
- ☐ Принтер дээр шингэн асгахгүй байхад анхаарал хандуулж, принтерт нойтон гараар хүрч ажиллуулахгүй байх.
- ☐ Зүрхний хэм хэмжигчээс принтерийг 22 см-с доошгүй зайд байрлуулна. Энэхүү принтерээс гарах радио долгион зүрхний хэм хэмжигчийн ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.
- ☐ LCD дэлгэц гэмтсэн бол, худалдааны төлөөлөгчтэйгөө холбоо барь. Шингэн кристал уусмалыг гартаа хүргэвэл, тэр хэсгийг саван, усаар сайтар угаана. Шингэн кристал уусмалыг нүдэндээ оруулбал, нэн даруй усаар зайлж угаана. Сайн зайлсны дараа ч таагүй байдал мэдрэгдэж, сайтар харахгүй хэвээр байвал, эмчид яаралтай үзүүлнэ.

Чухал заавар

- ❑ Принтер хүнд бөгөөд хоёроос доош тооны хүн өргөж авч явж болохгүй. Хэрэв Цаасан Кассет 1-ээс бусад цаасны хайрцаг суулгасан бол принтерийг өргөхөөс өмнө тэдгээрийг устгана уу. Принтерийг өргөх үедээ хоёр эсвэл түүнээс олон хүн доор харуулсан зөв байрлалд зогсох шаардлагатай.



- ❑ Бэх нийлүүлэх портны эргэн тойронд тодорхой хэмжээний бэх үлдсэн байдаг тул та ашигласан бэхээр хангах нэгжүүд-тай ажиллах үед болгоомжтой байна уу.
 - ❑ Бэхийг арьсандаа хүргэвэл, уг газраа саван, усаар сайтар угаана.
 - ❑ Бэхийг нүдэндээ оруулбал, нэн даруй усаар зайлж угаана. Сайн зайлсны дараа ч таагүй байдал мэдрэгдэж, сайтар харахгүй байвал, эмчид яаралтай үзүүлнэ.
 - ❑ Бэхийг амандаа оруулбал, нэн даруй эмчид үзүүлнэ.
- ❑ бэх нийлүүлэх нэгж, засвар үйлчилгээний хайрцгийг задалж болохгүй, эс тэгвээс бэх таны нүдэнд орж, эсвэл арьсан дээр асгарна.
- ❑ бэхээр хангах нэгжүүд-г хэт хүчтэй савлаж болохгүй; эс тэгвээс бэхээр хангах нэгжүүд-с асгарч болно.
- ❑ бэхээр хангах нэгжүүд, засвар үйлчилгээний хайрцгийг хүүхдийн гар хүрэхгүй газар хадгална.

Принтерийн зөвлөгөө, анхааруулга

Принтер болон өөрийн эд хөрөнгөө эвдрэл гэмтлээс сэргийлэхийн тулд дараах зааврыг дагаж мөрдөнө үү. Энэхүү гарын авлагыг ирээдүйд ашиглахын тулд хадгална уу.

Принтерийг тохируулах зөвлөгөө болон анхааруулга

- ❑ Принтерийн хоолой, нээлхийг хааж, таглахгүй байх.
- ❑ Принтерийн шошго дээр заасан тэжээлийн эх үүсвэрийн төрлийг ашиглах.
- ❑ Байнга асаж унтарч байдаг хувилагч машин, эсвэл агаарын хяналтын систем зэрэгтэй нэг хэлхээнд байрлах залгуурт залгахгүй байх.
- ❑ Ханын унтраалга, эсвэл автомат цаг зэргийн удирддаг цахилгаан залгуур хэрэглэхээс зайлсхийх.
- ❑ Чанга яригч, утасгүй телефон утасны үүр зэрэг цахилгаан соронзон нөлөөлөл бүхий боломжит эх үүсвэрээс компьютерийн ерөнхий системийг хол байрлуулах.

Чухал заавар

- ☐ Эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсыг зулгарах, зүсэгдэх, эрчлэх, хугарах, нугаларахаас сэргийлж байрлуулна. Эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсан дээр эд юмс тавьж болохгүй бөгөөд эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсан дээр гишгэх гүйхийг хориглоно. Трансформатор руу орж байгаа болон гарч байгаа төгсгөлийн хэсэг дээр эрчим хүчний тэжээлийн цахилгаан утсыг шулуун байлгахад онцгой анхаарал хандуулна.
- ☐ Принтер дээр уртасгагч цахилгаан утас ашиглах бол, уртасгагч утсанд залгах төхөөрөмжийн нийт ампер нь цахилгаан утасны амперийн хэмжээнээс хэтрэхгүй байхад анхаарал хандуулна. Түүнчлэн, ханын залгуур залгасан бүх төхөөрөмжийн амперийн хэмжээ ханын залгуурын нийт амперийн хэмжээнээс хэтрэхгүй байхад анхаарна.
- ☐ Та энэхүү принтерийг Герман улсад ашиглахаар төлөвлөж байгаа бол, принтерийн богино холболтын хамгаалалт, хэт гүйдлийн хамгаалалтын зохих түвшинг хангахын тулд ашиглах барилга дээрх суурилуулалтыг 10 эсвэл 16 амперын хэлхээ таслагчаар хамгаалах ёстой.
- ☐ Принтерийг компьютер болон бусад төхөөрөмжтэй кабель утсаар холбох үед холболт зөв чиглэлтэй хийгдсэн эсэхийг бататгах хэрэгтэй. Холбогч бүрт холболтын цорын ганц зөв чиглэл байдаг. Холбогчийг буруу чиглэлээр хийх нь кабель утсаар холбосон хоёр төхөөрөмжийн аль алинд эвдрэл гэмтэл учруулах боломжтой.
- ☐ Принтерийг принтерийн сууриас бүх чиглэлд сунгах боломжтой тэгш, тогтвортой гадаргуу дээр байрлуулна. Принтерийг тодорхой өнцгөөр хазайлгасан үед зохих ёсоор ажиллахгүй.
- ☐ Принтерийн тагийг бүрэн нээх боломжтой байхын тулд принтерийн дээд хэсэгт зайтай байлгах.
- ☐ Цаасыг бүрэн гаргаж авах боломжтой байхын тулд принтерийн урд талд хангалттай зай үлдээх.
- ☐ Температур, чийгшлийн эрс өөрчлөлт бүхий газарт байрлуулахаас зайлсхийх. Түүнчлэн, принтерийг нарны шууд тусгал, хурц гэрэл, халууны эх үүсвэрээс хол байлгана.

Принтерийг ашиглах зөвлөгөө болон анхааруулга

- ☐ Принтерийн сувгаар дамжуулж эд юмс оруулахгүй байх.
- ☐ Хэвлэж байхад принтер дотор гараа оруулахгүй байх.
- ☐ Принтерийн дотор талын цагаан хавтгай кабель утсанд гараа хүргэхгүй байх.
- ☐ Принтерийн дотор талд болон эргэн тойронд шатамхай хий агуулсан аэрозолын бүтээгдэхүүн ашиглахгүй байх. Тэдгээрийг ашигласнаар гал түймэр гарч болно.
- ☐ Принтерийн толгойг гараар хөдөлгөхгүй байх; эс тэгвээс, та принтерт эвдрэл гэмтэл учруулж болно.
- ☐ Үргэлж  товчийг ашиглаж принтерийг унтрааж байх.  гэрэл анивчихаа болих хүртэл принтерийн залгуурыг салгахгүй, эсвэл тэжээлийг залгуураар унтраахгүй байх.
- ☐ Та принтерийг удаан хугацаагаар ашиглахгүй бол, тэжээлийн цахилгаан утсыг цахилгааны залгуураас салгахаа мартуузай.

Принтерийг зөөвөрлөх, хадгалах зөвлөгөө болон анхааруулга

- ☐ Принтерийг хадгалж, тээвэрлэх үед, үүнийг хазайлгах, босоо байрлалд тавих, хөмөрч тавихаас болгоомжлох хэрэгтэй.
- ☐ Принтерийг тээвэрлэхээс өмнө, принтерийн толгой үндсэн (баруун өнцөг) байрлалд байгааг мөн бэхээр хангах нэгжүүд-г суурилуулалдсан эсэхийг шалгаарай.

Чухал заавар

Утасгүй холболт бүхий принтерийг ашиглах зөвлөгөө ба анхааруулга

- ❑ Энэхүү принтерээс гарч буй радио долгион эрүүл мэндийн электрон тоног төхөөрөмжид сөрөг нөлөө үзүүлж, тэдгээрийг бүрэн гүйцэд ажиллагаанд саад учруулж болно. Эрүүл мэндийн байгууламж, эсвэл эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн ойролцоо тус принтерийг ашиглахдаа, эрүүл мэндийн байгууламжийг төлөөлж буй эрх бүхий ажилтны өгсөн зааварчилгааг дагаж, эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн бүх анхааруулга, санамжийг дагах хэрэгтэй.
- ❑ Энэхүү принтерээс гарч буй радио долгион автомат хаалга болон галын дохио зэрэг автомат хяналттай төхөөрөмжийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай ба үйл ажиллагааны доголдлоос болж осол зөрчилд хүргэж болно. Энэхүү принтерийг автомат хяналттай төхөөрөмжийн дэргэд ашиглахдаа, тэдгээр төхөөрөмжийн бүх анхааруулга, санамжийг дагаж мөрдөнө үү.

LCD дэлгэц ашиглах талаар өгөх зөвлөгөө, анхааруулга

- ❑ The LCD дэлгэц нь цөөн тооны жижиг цайвар ба хар цэгийг агуулж болох бөгөөд тохируулгаасаа болоод үүнд ижил бус цайралттай байж болно. Эдгээр нь хэвийн бөгөөд энэ нь ямар нэг байдлаар эвдэрч гэмтсэн гэдгийг илэрхийлэхгүй болно.
- ❑ Цэвэрлэх үед хуурай, зөөлөн даавууг зөвхөн ашиглана. Шингэн эсвэл химийн бодистой угаагч бодис ашиглаж болохгүй.
- ❑ LCD дэлгэц хүнд цохилтод өртвөл гадаад хүрээ нь эвдэрч гэмтэж болно. Дэлгэцийн гадаргуу бутарч, хагарсан бол худалдааны төлөөлөгчтэйгөө холбоо барьж, хагарсан хэсэгт хүрч түүнийг салгахыг оролдож болохгүй.

Администраторын нууц үгийн тухайд санамж


Энэ принтер танд сүлжээнд холбогдох үед төхөөрөмж дээр хадгалагдсан төхөөрөмжийн болон сүлжээний тохиргоо руу зөвшөөрөлгүй хандаж, өөрчлөлт оруулахаас сэргийлэхийн тулд администраторын нууц үг тохируулах боломж олгоно.

Администраторын нууц үгийн өгөгдмөл утга

Администраторын нууц үгийн өгөгдмөл утга нь энэ харуулсантай адил бүтээгдэхүүний өөрийнх нь шошго дээр хэвлэгдсэн байдаг. Шошго наасан байрлал нь таг нээгддэг талд, ар талд, эсвэл доор нь гэх мэтээр бүтээгдэхүүнээсээ хамаардаг.

Чухал заавар

Доорх зураг бол шошгыг принтерийн таг нээгдэх хажуу талд байрлуулж наасан жишээ юм.



Хэрэв (1) болон (2) гэсэн хоёр шошго наасан байвал шошго (1) дээр НУУЦ ҮГ гэсний хажууд бичсэн утга нь өгөгдмөл утга юм. Энэ жишээ дээр өгөгдмөл утга нь 03212791 байна.

Хэрэв зөвхөн (2) гэсэн шошго наасан байвал шошго (2) дээр хэвлэсэн серийн дугаар нь өгөгдмөл утга юм. Энэ жишээ дээр өгөгдмөл утга нь X3B8153559 байна.

Администраторын нууц үгийг тохируулаагүй байх

Таныг Web Config-т хандах үед гарч ирэх нууц үг оруулах дэлгэц дээр нууц үг тохируулна уу.

Холбогдох мэдээлэл

➔ [129 хуудас дээрх "Вэб тохируулгыг вэб хөтөч дээр ажиллуулах"](#)

Администраторын нууц үгийг өөрчлөх

Аюулгүй байдлын үүднээс анхны нууц үгийг солихыг зөвлөж байна.

Принтерийн хянах самбар, Web Config, болон Epson Device Admin дээрээс солих боломжтой. Нууц үгийг солихдоо дор хаяж 8 байт үсэг тоон тэмдэгт болон ялгах тэмдэгтэй тохируулаарай.

Холбогдох мэдээлэл

➔ [129 хуудас дээрх "Вэб тохируулгыг вэб хөтөч дээр ажиллуулах"](#)

Администраторын нууц үгийг оруулахыг шаарддаг үйлдлүүд

Хэрэв та дараах үйлдлүүдийг хийхэд администраторын нууц үг оруулахыг танд сануулбал принтер дээр тохируулсан администраторын нууц үгийг оруулна уу.

- ☐ Компьютер эсвэл ухаалаг төхөөрөмжөөс принтерийн техник хангамжийг шинэчлэх үед
- ☐ Web Config-н дэвшилтэт тохиргоонд нэвтрэх үед
- ☐ Принтерийн тохиргоог өөрчлөх боломжтой аппликэйшнийг ашиглан тохируулах үед
- ☐ Принтерийн хяналтын самбар дээрх администратороор түгжигдсэн цэсийг сонгоход

Администраторын нууц үгийг анхны утгад нь тохируулах

Та администраторын тохиргоо цэсээс администраторын нууц үгийг өгөгдмөл тохиргоо руу нь буцаах боломжтой. Хэрэв та нууц үгээ мартсан бөгөөд өгөгдмөл тохиргоо руу буцаж чадахгүй байвал Epson-н тусламжтай холбогдож үйлчилгээний хүсэлт тавих хэрэгтэй.

Холбогдох мэдээлэл


- ➔ 79 хуудас дээрх "Принтерийн хянах самбараас Сүлжээний тохиргоог сэргээх"
- ➔ 188 хуудас дээрх "Хаанаас тусламж авах вэ"

Хувийн мэдээллээ хамгаалах

Та тус принтерийг хэн нэгэнд өгөх, эсвэл хаяхдаа, хянах самбар дээрх **Тохиргоо > Принтерийн тохиргоо > Системийн Удирдлага > Өгөгдмөл тохиргоог сэргээх > Бүх тохиргоо**-г сонгосноор принтерийн санах ойд хадгалагдсан бүх хувийн мэдээллээ арилгаж болно. Мөн та принтерийн дотоод санах ойн өгөгдлийг устгахдаа, хянах самбар дээрх **Тохиргоо > Принтерийн тохиргоо > Системийн Удирдлага > Дотоод Санах ойг Арилгах > Бүгдийг Арилгах**-г сонгоно уу.

Принтерийн үндсэн мэдээлэл


Эд ангийн нэр ба функцүүд



①	Хянах самбар	Принтерийг ажиллуулна. Та хяналтын самбарын харагдах өнцгийг өөрчилж болно.
②	Цаасны кассет 1 (C1)	Цаасыг ачаална.
③	Цаасны кассет 2 (C2)*	Сонголтын чанартай цаасны кассетын зүйл. Цаасыг ачаална.
④	Цаасны кассет 3 (C3)	


* Худалдан авах хугацаанаас хамааран багцад багтаж болно.

Принтерийн үндсэн мэдээлэл




①	Ирмэг заагч	Цаасыг шууд принтерт татна. Цаасны ирмэгт тултал гулгуул.
②	Цаасны дэмжлэг	Ачаалсан цаасанд тулгуур болно.
③	Тэжээгчийн хамгаалалт	Принтерт гадны биет орохоос сэргийлнэ. Энэхүү хаалтыг байнга хаалттай байлга.
④	Арын цаас тэжээгүүр (B)	Цаасыг ачаална.
⑤	Гаралтын тэвш	Гаргасан цаасыг тогтооно.
⑥	Ирмэг заагч	Цаасыг шууд принтерт татна. Цаасны ирмэгт тултал гулгуул.
⑦	Цаасны кассет	Цаасыг ачаална.

Принтерийн үндсэн мэдээлэл




①	Принтерийн таг (J)	Принтер доторх гацсан цаасыг авахын тулд үүнийг онгойлго.
②	Хэвлэгчийн толгой	Бэхийг шүршинэ.
③	Бэх нийлүүлэх нэгж тавиур	бэх нийлүүлэх нэгж-ийг тавина.
④	Нүүрэн талын гадар (A)	бэхээр хангах нэгжүүд-г солихдоо нээ.
⑤	Урд таг түгжигч	Урд тагийг түгжинэ.

Принтерийн үндсэн мэдээлэл



1	LAN порт	LAN кабелийг холбоно.
2	USB порт	USB кабелийг холбоно.
3	Үйлчилгээний USB порт	Хожим ашиглах USB порт. Наалтыг авч болохгүй.
4	AC оролт	Тэжээлийн залгуурыг холбоно.
5	Арын таг (D)	Гацсан цаасыг авахдаа нээнэ.
6	Арын таг (E)	Гацсан цаасыг авахдаа нээнэ.
7	Засварын хайрцгийн хаалт (H)	Засвар үйлчилгээний хайрцгийг солих үед нээ.

Хяналтын самбар




1	Принтерийг асааж унтраана. Тэжээлийн гэрэл унтарсныг шалгасны дараагаар тэжээлийн залгуурыг салгана.
2	Үндсэн дэлгэцийг харуулна.

Принтерийн үндсэн мэдээлэл

3	Цаасны тохиргоо дэлгэц гарч ирнэ. Цаасны эх үүсвэр бүрийн цаасны хэмжээ, цаасны төрлийн тохиргоог сонгох боломжтой.
4	Одоогийн үйл ажиллагааг зогсооно.
5	Нөхцөл байдлаас шалтгаалан олон төрлийн функцэнд хэрэглэнэ.
6	Зүйлийг сонгохын тулд ◀, ▶, ▲, ба ▼ дээр дарна. Өөрийн сонголтоо баталгаажуулж сонгосон тохиргоогоо ажиллуулахын тулд ОК дээр дарна.
7	Өмнөх дэлгэц рүү буцах.
8	Принтер өгөгдөл дамжуулж байхад анивчина. Жагсаалттай ажил байгаа үед асна.
9	Алдаа гарвал гэрэл анивчих эсвэл асна.

Үндсэн дэлгэцийн тохиргоо



1	Принтерт тэмдэг болгон тохируулсан зүйлсийг илэрхийлнэ. Одоогийн тохиргоог шалгах эсвэл тохиргооны цэс бүрт хандах бол тэмдэгтийг сонго. Энэ үйлдлийн мөр зөвхөн нүүр дэлгэц дээр харагдана.
2	Горим бүрийг харуулна.
3	Байгаа товчуудыг харуулна.

LCD дэлгэц дээр харагдах тэмдгүүд

Принтерийн төлөвөөс шалтгаалж дараах тэмдэг LCD дэлгэц дээр гарч ирэх болно.


	Хангамжийн төлөв дэлгэц гарч ирнэ. Та бэхний ойролцоолсон түвшин, засвар үйлчилгээний хайрцгийн барагцаалсан ашиглалтын хугацааг шалгаж болно.
--	--

Принтерийн үндсэн мэдээлэл

	Сүлжээний холболтын төлвийг илэрхийлнэ. Одоогийн тохиргоог шалгаж өөрчлөхийн тулд энэ тэмдгийг сонгоно уу. Энэ бол дараах цэсийн богино холбоос юм. Тохиргоо > Принтерийн тохиргоо > Сүлжээний тохиргоо > Wi-Fi Тохируулга
	 Принтерийг утастай сүлжээ (Ethernet)-нд холбоогүй эсвэл тохируулаагүй байна.
	 Принтерийг утастай (Ethernet) сүлжээнд холбосон байна.
	 Принтер утасгүй (Wi-Fi) сүлжээнд холбогдоогүй байна.
	 Принтер нь SSID буюу тохируулаагүй IP хаягийг хайж байна эсвэл утасгүй (Wi-Fi) сүлжээтэй асуудалтай байна.
	 Принтер утасгүй (Wi-Fi) сүлжээнд холбогдсон байна. Баганы тоо нь холболтын дохионы хүчийг харуулна. Олон багана байх тусам, холболт хүчтэй байна.
	 Принтер Wi-Fi Direct (Энгийн AP) дээр байгаа утасгүй (Wi-Fi) сүлжээнд холбогдоогүй байна.
	 Принтер Wi-Fi Direct (Энгийн AP) дээр байгаа утасгүй (Wi-Fi) сүлжээнд холбогдсон байна.
 	Чимээгүй горим принтер дээр тохируулагдсан эсэхийг илэрхийлнэ. Энэ онцлогийг идэвхжүүлсэний дараа принтерийн үйл ажиллагаанаас үүдсэн чимээ буурч принтерийн хурд удааширч болзошгүй. Гэхдээ сонгосон цаасны төрөл болон хэвлэлтийн чанараас хамаарч чимээ буурахгүй байж болзошгүй.
	Тусламж дэлгэц гарч ирнэ. Та ажиллуулах зааварчилгаа, асуудлыг шийдвэрлэх арга замыг үзэж болно.
	Нэмэлт мэдээлэл байгааг илтгэнэ. Мессежийг харуулах бол энэ тэмдгийг сонгоно уу.
	Зүйлсэд асуудал байгааг илтгэнэ. Асуудлыг хэрхэн шийдэхийг шалгах бол энэ тэмдгийг сонгоно уу.


Үндсэн үйл ажиллагаа

▲, ▼, ◀, ▶ товчлууруудыг ашиглан анхаарлыг шилжүүлэх ба зүйлүүдийг сонгоод ОК товчийг дарж сонголтоо баталгаажуулах эсвэл сонгосон хэсгийг идэвхжүүлж болно.




Принтерийн үндсэн мэдээлэл

▲, ▼, ◀, ▶ товчлууруудыг ашиглан анхаарлыг тохиргооны зүйлрүү шилжүүлж OK товчийг дарж асааж унтраана.




Утга, нэр, хаяг болон бусад зүйлсийг оруулахын тулд ▲, ▼, ◀, ▶ товчлууруудыг ашиглан анхаарлыг оруулах хэсэгт шилжүүлэх ба OK товчийг даран дэлгэцэн дээрх гарыг харуулна.



Тэмдэгтийг оруулах

Дэлгэц дээрх товчлуурт гар

Та сүлжээний тохиргоог хийх болон бусад үед дэлгэцэн дээрх гарыг ашиглан тэмдэгт болон ялгах тэмдгийг оруулж болно.



Принтерийн үндсэн мэдээлэл

Тэмдэглэл:


Тохиргооны заалтуудаас хамаарч таних тэмдгүүд ялгаатай байна.

①	Тэмдэгтийн тоог илэрхийлнэ.
②	Курсорыг оруулах байрлалд зөөнө.
③	Том, жижиг үсгүүд, тоо, тэмдэгтүүдийн хооронд шилжинэ. Мөн та  товчлуурыг ашиглан тэднийг сольж болно.
④	Тэмдэгтийн төрөл хооронд сэлгэнэ. Та үсэг тоо болон тэмдэглэгээнүүдийг оруулж болно. Мөн та  товчлуурыг ашиглан тэднийг сольж болно.
⑤	Гарын байршлыг өөрчилнө.
⑥	Тухайн зүйлийг сонгож байнга ашигладаг э-шуудангийн домэйн хаяг эсвэл URL-ийг оруулна.
⑦	Сул зай оруулна.
⑧	Оруулсан тэмдэгтийг баталгаажуулна.
⑨	Зүүн тал руу тэмдэгтийг устгана.

Хөдөлгөөнт дүрсийг харах

Та LCD дэлгэц дээр цаас оруулах болон гацсан цаасыг салгаж авах зэрэг ашиглалтын заавар бүхий хөдөлгөөнт дүрсийг харах боломжтой.

- ☐ Үндсэн дэлгэцээс  сонго: Туслах дэлгэц гарч ирнэ. **Хэрхэн** товшиж, дараа нь харахыг хүссэн зүйлсээ сонго.
- ☐ Ашиглалтын дэлгэцийн доод талд байгаа **Хэрхэн** товших: Агуулгын нууцлалтай хөдөлгөөнт дүрсийг харуулна.



①	Нийт алхамын тоо болон одоогийн алхамын тоог илтгэнэ. Дээрх жишээгээр, энэ 2 – 4 алхамыг үзүүлж байна.
②	◀ товчийг дарж өмнөх алхамуу буцна.

Принтерийн үндсэн мэдээлэл

3	Одоогийн алхамаар дамжуулж таны явцыг илтгэнэ. Ахицын мөр эцэстээ хүрэх үед хөдөлгөөнт дүрс давтана.
4	► товчийг дарж дараагийн алхамруу шилжинэ.

Принтерийг бэлдэх

Цаасуудыг ачаалах

Бэлэн байгаа цаас ба багтаамж

Тэмдэглэл:

Харагдаж буй цаасны хэмжээ нь драйвераас хамааран ялгаатай байна.

Жинхэнэ Epson цаас

Өндөр чанартай хэвлэлтийг гаргахын тулд жинхэнэ Epson цаасыг ашиглахыг Epson зөвлөж байна.

Тэмдэглэл:

- ☐ Epson-ы универсаль принтерийн драйвер ашиглан хэвлэх үед Жинхэнэ Epson боломжгүй.
- ☐ Цаасны олдоц байрлалаас шалтгаалж ялгаатай байна. Өөрийн бүсийн цаасны олдцын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг авахын тулд Epson тусламж үйлчилгээтэй холбоо барина уу.
- ☐ Хэрэглэгчийн тодорхойлсон хэмжээтэй жинхэнэ Epson цаасан дээр хэвлэж байх үед зөвхөн **Стандарт** эсвэл **Normal** хэвлэлтийн чанарыг ашиглах боломжтой. Зарим принтерийн драйвер дээр илүү сайн чанарын хэвлэлтийг сонгож болох боловч, эцсийн хэвлэлт **Стандарт** эсвэл **Normal** чанараар л хэвлэгдэнэ.

Баримт хэвлэхэд тохиромжтой цаас



Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Хуудас)			2-талт Хэвлэлт
		Цаасан Кассет 1	Цаасан Кассет 2 ~ Цаасан Кассет 3	Арын Цаасны Дайз	
Epson Bright White Ink Jet Paper	A4	200	400	50	Автомат, Гар аргаар*

* Зөвхөн арын цаас тэжээгүүрийг ашиглан 2 талаар хэвлэх ажлыг гараар гүйцэтгэнэ үү. Нэг талд нь аль хэдийн хэвлэсэн 30 хүртэлх хуудсыг ачаалах боломжтой.

Принтерийг бэлдэх

Баримт болон зураг хэвлэхэд тохиромжтой цаас



Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Хуудас)			2-талт Хэвлэлт
		Цаасан Кассет 1	Цаасан Кассет 2 ~ Цаасан Кассет 3	Арын Цаасны Дайз	
Epson Photo Quality Ink Jet Paper	A4	80	–	70	–
Epson Matte Paper- Heavyweight	A4	50	–	20	–
Epson Double-Sided Matte Paper	A4	20	–	20	–

Зураг хэвлэхэд тохиромжтой цаас



Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Хуудас)			2-талт Хэвлэлт
		Цаасан Кассет 1	Цаасан Кассет 2 ~ Цаасан Кассет 3	Арын Цаасны Дайз	
Epson Ultra Glossy Photo Paper	A4, 13×18 см (5×7 инч), 10×15 см (4×6 инч)	50	–	20	–
Epson Premium Glossy Photo Paper	A4, 13×18 см (5×7 инч), 16:9 өргөн хэмжээтэй (102×181 мм), 10×15 см (4×6 инч)	50	–	20	–
Epson Premium Semigloss Photo Paper	A4, 10×15 см (4×6 инч)	50	–	20	–
Epson Photo Paper Glossy	A4, 13×18 см (5×7 инч), 10×15 см (4×6 инч)	50	–	20	–

Холбогдох мэдээлэл

➔ 16 хуудас дээрх "Эд ангийн нэр ба функцүүд"

Принтерийг бэлдэх

Худалдаанд бэлэн байгаа цаас

Тэмдэглэл:

Half letter, SP1 (210×270 мм), SP2 (210×149 мм), SP3 (100×170 мм), SP4 (130×182 мм), SP5 (192×132 мм) ба 16K (195×270 мм) хэмжээнүүдийг PostScript принтерийн драйверээр хэвлэх боломжгүй.

Ердийн цаас

Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Хуудас)			2-талт Хэвлэлт
		Цаасан Кассет 1	Цаасан Кассет 2 ~ Цаасан Кассет 3	Арын Цаасны Дайз	
Цулгүй цаас, Хувилах цаас	Letter ^{*3} , A4, Executive ^{*3} , B5, A5, SP1 (210×270 мм), 16K (195×270 мм)	Ирмэг заагч дээрх  тэмдгийн заасан шугам хүртэл.		80	Автомат, Гар аргаар ^{*1, *2}
Логотой цаас	Legal, Indian-Legal, 8.5×13 инч, Half letter ^{*3} , A6, B6, SP2 (210×149 мм), SP3 (100×170 мм), SP4 (130×182 мм)	Ирмэг заагч дээрх  тэмдгийн заасан шугам хүртэл.		80	Гар аргаар ^{*1, *2}
Дахин боловсруулсан цаас	SP5 (192×132 мм)	Ирмэг заагч дээрх  тэмдгийн заасан шугам хүртэл.	—	80	Гар аргаар ^{*1, *2}
Өнгөт цаас	Хэрэглэгчийн Тодорхойлсон ^{*3} (мм) 89×127 – 215.9×148 89×148 – 100×355.6	Ирмэг заагч дээрх  тэмдгийн заасан шугам хүртэл.	—	80	Гар аргаар ^{*1, *2}
Урьдчилж хэвлэсэн цаас	Хэрэглэгчийн Тодорхойлсон ^{*3} (мм) 100×148 – 215.9×355.6	Ирмэг заагч дээрх  тэмдгийн заасан шугам хүртэл.		80	Автомат ^{*5} , Гар аргаар ^{*1, *2}
Өндөр чанартай ердийн цаас	Хэрэглэгчийн Тодорхойлсон ^{*3} (мм) 64×127 – 215.9×355.6	—	—	80	Гар аргаар ^{*2}
	Хэрэглэгчийн Тодорхойлсон ^{*3} (мм) 64×355.6 – 215.9×6000	—	—	1	Гар аргаар

*1 Зөвхөн арын цаасны дайз-г ашиглан 2 талаар хэвлэх ажлыг гараар гүйцэтгэнэ үү.

*2 Нэг талд нь аль хэдийн хэвлэсэн 30 хүртэлх хуудсыг ачаалах боломжтой.

*3 Зөвхөн компьютероос хэвлэх боломжтой.

*4 Нэг талд нь аль хэдийн хэвлэсэн 5 хүртэлх хуудсыг ачаалах боломжтой.

*5 Автоматаар 2-талт хэвлэх бол, 148×210 – 215.9×297 мм хэмжээтэй цаас боломжтой.

Принтерийг бэлдэх

Зузаан Цаас

Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Хуудас)			2-талт Хэвлэлт
		Цаасан Кассет 1	Цаасан Кассет 2 ~ Цаасан Кассет 3	Арын Цаасны Дайз	
Зузаан цаас (91–160 г/м²)	Letter* ² , A4, Executive* ² , B5, A5, SP1 (210×270 мм), 16K (195×270 мм)	90	250	30	Автомат, Гар аргаар* ¹ , * ³
	Legal, 8.5×13 инч, Half letter* ² , A6, B6, SP2 (210×149 мм), SP3 (100×170 мм), SP4 (130×182 мм)	90	250	30	Гар аргаар* ¹ , * ³
	SP5 (192×132 мм)	90	–	30	Гар аргаар* ¹ , * ³
	Хэрэглэгчийн Тодорхойлсон* ² (мм) 89×127 – 215.9×148 89×148 – 100×355.6	90	–	30	Гар аргаар* ¹ , * ³
	Хэрэглэгчийн Тодорхойлсон* ² (мм) 100×148 – 215.9×355.6	90	250	30	Автомат* ⁴ , Гар аргаар* ¹ , * ³
	Хэрэглэгчийн Тодорхойлсон* ² (мм) 64×127 – 215.9×355.6	–	–	30	Гар аргаар* ³
	Хэрэглэгчийн Тодорхойлсон* ² (мм) 64×355.6 – 215.9×1117.6	–	–	1	Гар аргаар
Зузаан цаас (161–256 г/м²)	Legal, 8.5×13 инч, Letter* ² , A4, Executive* ² , B5, A5, Half letter* ² , A6, B6, SP1 (210×270 мм), SP2 (210×149 мм), SP3 (100×170 мм), SP4 (130×182 мм), SP5 (192×132 мм), 16K (195×270 мм)	–	–	30	Гар аргаар* ³
	Хэрэглэгчийн Тодорхойлсон* ² (мм) 64×127 – 215.9×355.6	–	–	30	Гар аргаар* ³
	Хэрэглэгчийн Тодорхойлсон* ² (мм) 64×355.6 – 215.9×1117.6	–	–	1	Гар аргаар

*1 Зөвхөн арын цаасны дайз-г ашиглан 2 талаар хэвлэх ажлыг гараар гүйцэтгэнэ үү.

Принтерийг бэлдэх

- *2 Зөвхөн компьютероос хэвлэх боломжтой.
- *3 Нэг талд нь аль хэдийн хэвлэсэн 5 хүртэлх хуудсыг ачаалах боломжтой.
- *4 Автоматаар 2-талт хэвлэх бол, 148×210 – 215.9×297 мм хэмжээтэй цаас боломжтой.

Дугтуйнууд


Хэрэгслийн Нэр	Хэмжээ	Ачаалах Багтаамж (Дугтуйнууд)			2-талт Хэвлэлт
		Цаасан Кассет 1	Цаасан Кассет 2 ~ Цаасан Кассет 3	Арын Цаасны Дайз	
Дугтуй	Дугтуй #10, Дугтуй DL, Дугтуй C6	10	–	10	–
	Дугтуй C4	–	–	1	–

Холбогдох мэдээлэл


➔ 16 хуудас дээрх “Эд ангийн нэр ба функцүүд”

Цаас ашиглахтай холбоотой анхааруулга

- ☐ Цаастай цуг ирэх зааврын хуудсыг унших.
- ☐ Жинхэнэ Epson цаасны тусламжтай өндөр чанартай хэвлэх бол цаасанд дагалдан ирсэн хуудсанд заасан орчинд байгаа цаасыг ашиглана уу.
- ☐ Ачаалахаас өмнө цаасны өнцгийг имэрч эгнүүлэх. Фото цаасыг имэрч нугалж болохгүй. Тэгсэн тохиолдолд цаасны хэвлэх талд гэмтэл учруулна.



- ☐ Хэрэв цаас нугаларсан бол ачаалахаас өмнө түүнийг тэнийлгэж, эсрэг талаар нь бага зэргээр нугална. Нугаларсан цаасан дээр хэвлэх нь хэвлэх үед цаасыг бөглөрөх, бохирдоход хүргэнэ.



Принтерийг бэлдэх

- ❑ Үрчийсэн, урагдсан, зүссэн, нугалсан, чийгтэй хэт зузаан, эсвэл хэт нимгэн наалт наасан цаасыг ашиглахгүй. Эдгээр төрлийн цаасыг ашигласнаас цаас бөглөрөх, хэвлэмэл материал бохирдоход хүргэнэ.
- ❑ Уртынхаа дагуу ширхэгтэй цаас ашиглаж байгаа эсэхээ магадлаарай. Хэрэв та ямар төрлийн цаас ашиглаж байгаагаа сайн мэдэхгүй байвал, цаасны баглааг шалгах буюу үйлдвэрлэгчтэй холбоо барьж цаасны үзүүлэлтийг магадлаарай.

Холбогдох мэдээлэл


➔ [164 хуудас дээрх "Принтерийн үзүүлэлт"](#)

Цаасан Кассет руу цаас ачаалах

Тэмдэглэл:


Хэрэв сонголтын чанартай цаасан хуурцгийн хэсгийг суурилуулсан бол нэгэн зэрэг хоёр цаасан хуурцгийг татаж авч болохгүй.

1. Принтер ажиллаагүй байгаа эсэхийг шалгаад цаасан кассет-ийг татаж гарга.




Принтерийг бэлдэх

2. Урд талын ирмэг заагчийг эцэст нь тулган гүйлгэж, дараа нь ашиглахыг хүссэн цаасны хэмжээг тохируулахын тулд хажуугийн ирмэг заагчийг гүйлгэнэ үү.




Тэмдэглэл:

A4 хэмжээнээс том цаас ашиглах үед, цаасан кассет-ийг сунгана.



3. Доош харуулж хэвлэх талаар нь цаасыг оруулж, урд талын ирмэг заагчийг цаасны ирмэгт тулгана үү.



Принтерийг бэлдэх




Чухал:

Тухайн цаасанд заасан хуудасны дээд тооноос илүү ихийг бүү ачаалаарай. Цулгүй цаасны хувьд, ирмэг заагч доторх  тэмдэгтийн заасан шугамаас дээш гаргаж ачаалж болохгүй. Зузаан цаасны хувьд, ирмэг заагч доторх  тэмдэгтийн заасан шугамаас дээш гаргаж ачаалж болохгүй.

4. цаасан кассет-ийг цааш нь бүрэн түлхэж оруул.

Тэмдэглэл:

Цаасан хуурцгийг сунгахад, энэ нь принтерээс бага цухуйж гарна.




5. Хянах самбар дээр, цаасан кассет-т ачаалсан цаасныхаа хэмжээ, төрлийг тохируулна.

Тэмдэглэл:

Та мөн хянах самбар дээрх  товч дээр дарж цаасны хэмжээ болон цаасны төрлийн тохиргооны дэлгэцийг харуулах боломжтой.

6. A4 хэмжээнээс илүү урт цаас ачаалахдаа гаралтын тэвшийг гулгуулж гаргаарай.




Холбогдох мэдээлэл


- ➔ 29 хуудас дээрх "Цаас ашиглахтай холбоотой анхааруулга"
- ➔ 25 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"
- ➔ 36 хуудас дээрх "Цаасны төрлийн жагсаалт"
- ➔ 35 хуудас дээрх "Дугтуй болон сануулга ачаалах"

Арын Цаасны Дайз руу цаас ачаалах


1. Тэжээгчийн хамгаалалтыг нээж, цаасны тулгуурыг сунгаж гаргана.



2. Ирмэг заагчийг гүйлгэнэ үү.



3. Хэвлэх талыг дээш нь харуулж арын цаасны дайз-н голд цаасыг ачаална.




Чухал:

- ❑ Тухайн цаасанд заасан хуудасны дээд тооноос илүү ихийг бүү ачаалаарай. Ердийн цаасны тухайд, ирмэг заагч доторх гурвалжин тэмдгийн яг дор байрлах шугамаас дээш гаргаж ачаалж болохгүй.
- ❑ Цаасны богино ирмэгийг эхлээд ачаална уу. Гэхдээ хэрэглэгчийн тодорхойлсон хэмжээтэй өргөнөөр урт ирмэгийг тохируулсан бол цаасны урт ирмэгийг эхлээд ачаална уу.

Принтерийг бэлдэх

Цоолбортой цаас




Тэмдэглэл:

Цоолбортой цаасыг дараах нөхцөлд ашиглаж болно. Автомат 2-талт хэвлэлтийг цоолбортой цаасанд ашиглах боломжгүй.

- ☐ Ачаалах Багтаамж: Нэг хуудас
- ☐ Боломжтой хэмжээ: A4, B5, A5, A6, Letter, Legal
- ☐ Үдэх нүх: Дээд эсвэл доод талдаа үдэх нүхтэй цаасыг бүү ачаал.
Цоолсон нүхэн дээгүүр хэвлэхээс сэргийлж файлынхаа хэвлэх байрлалыг тохируул.
- ☐ Цаасны тохиргоо: **Хэвлэмэл хуудас** эсвэл **Хэвлэмэл**-г цаасны төрлийн тохиргоогоор сонгох.

4. Ирмэгийн заагчийг цаасны ирмэг рүү гүйлгэ.




5. Хянах самбар дээр, арын цаасны дайз-т ачаалсан цаасныхаа хэмжээ, төрлийг тохируулна.

Тэмдэглэл:

Та мөн хянах самбар дээрх  товч дээр дарж цаасны хэмжээ болон цаасны төрлийн тохиргооны дэлгэцийг харуулах боломжтой.

6. A4 хэмжээнээс илүү урт цаас ачаалахдаа гаралтын тэвшийг гулгуулж гаргаарай.



Тэмдэглэл:

Үлдсэн цаасыг боодолд нь эргүүлж хийнэ. Та цаасыг принтер дээр үлдээвэл, цаас үрчийж, эсвэл хэвлэлийн чанар буурч магадгүй.


Принтерийг бэлдэх

Холбогдох мэдээлэл


- ➔ 29 хуудас дээрх "Цаас ашиглахтай холбоотой анхааруулга"
- ➔ 25 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"
- ➔ 36 хуудас дээрх "Цаасны төрлийн жагсаалт"
- ➔ 35 хуудас дээрх "Дугтуй болон сануулга ачаалах"
- ➔ 36 хуудас дээрх "Урт цаас ачаалах"

Дугтуй болон сануулга ачаалах


арын цаасны дайз дахь голын дугтуйг сөхөвчийг доош нь харуулан богино ирмэгийг эхэлж ачаалаад ирмэг заагчийг дугтуйны ирмэг рүү гулгуулна.



цаасан кассет дахь дугтуйг сөхөвчийг доош нь харуулаан ачаалаад ирмэг заагчийг дугтуйны ирмэг рүү гулгуулна.



- ☐ Ачаалахаас өмнө дугтуйн өнцгийг имэрч эгнүүлэх. Давхарласан дугтуйн дотор зай орсон бол, ачаалахаас өмнө тэдгээрийг доош нь дарж агаарыг гаргана.



- ☐ Үрчийсэн, эсвэл нугаларсан дугтуйг ашиглахгүй. Эдгээр дугтуйг ашигласнаас цаас бөглөрөх, хэвлэмэл материал бохирдоход хүргэнэ.
- ☐ Дугтуй, нэвт харагддаг дугтуйн дээрх наалдамтгай гадаргуутай дугтуйг ашиглахгүй.
- ☐ Хэт нимгэн дугтуй нь хэвлэх явцад нугаларах магадлалтай тул ашиглахаас зайлсхийх.

Принтерийг бэлдэх

Холбогдох мэдээлэл

- ➔ 25 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"
- ➔ 30 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 33 хуудас дээрх "Арын Цаасны Дайз руу цаас ачаалах"

Урт цаас ачаалах

Урт цаас ачаалахдаа зөвхөн арын цаасны дайз-г ашигла. Принтерт цаас ачаалахын өмнө хэвлэхийг хүссэн хэмжээгээрээ цаасыг тайр. **Хэрэглэгчийн тодорхойлсон**-ийг цаасны хэмжээний тохиргоогоор сонго.

- ☐ Цаасны төгсгөлийн хэсэг перпендикуляр тайрагдсан эсэхийг шалга. Муруй тайрвал цаас татахад асуудал үүсэж болно.
- ☐ Урт цаасыг гаралтын тавиурт хийж болохгүй. Цаасыг газар унагахгүй байхын тулд хайрцаг болон бусад зүйлсийг бэлд.
- ☐ Татагдаж байгаа эсвэл гарсан цаасанд хүрч болохгүй. Энэ нь таны гарыг гэмтээх эсвэл хэвлэх чанарыг буурахад хүргэж болно.

Холбогдох мэдээлэл

- ➔ 25 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"
- ➔ 33 хуудас дээрх "Арын Цаасны Дайз руу цаас ачаалах"

Цаасны төрлийн жагсаалт

Хамгийн шилдэг хэвлэмэл материалыг гаргахын тулд цаасанд тохирсон цаасны төрлийг сонгоно.

Хэрэгслийн Нэр	Хэрэгслийн төрөл			
	Хяналтын самбар	Принтерийн драйвер	PostScript принтерийн драйвер	Epson универсаль принтерийн драйвер
Epson Bright White Ink Jet Paper	Ердийн цаас	Ердийн цаас	Plain	Plain
Epson Ultra Glossy Photo Paper	Хэт гялгар	Epson Ultra Glossy	Epson Ultra Glossy	-
Epson Premium Glossy Photo Paper	Шилд. гялгар	Epson Premium Glossy	Epson Premium Glossy	-
Epson Premium Semigloss Photo Paper	Хагас шилд. гялгар	Epson Premium Semigloss	Epson Premium Semigloss	-
Epson Photo Paper Glossy	Гялгар	Photo Paper Glossy	Photo Paper Glossy	-

Принтерийг бэлдэх

Хэрэгслийн Нэр	Хэрэгслийн төрөл			
	Хяналтын самбар	Принтерийн драйвер	PostScript принтерийн драйвер	Epson универсаль принтерийн драйвер
Epson Matte Paper-Heavyweight Epson Photo Quality Ink Jet Paper	Матт	Epson Matte	Epson Matte	-
Зузаан цаас (91 – 160 г/м²)	Зузаан цаас1	Зузаан цаас1	Зузаан цаас1	Зузаан цаас1
Зузаан цаас (161 – 256 г/м²)	Зузаан цаас2	Зузаан цаас2	Зузаан цаас2	Зузаан цаас2

Тохиргоо-н цэсийн сонголтууд

Принтерийн үндсэн дэлгэц дээр байгаа **Тохиргоо**-ыг сонгож янз бүрийн тохиргоог хий.

Принтерийн тохиргоо-н цэсийн сонголтууд

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Тохиргоо > Принтерийн тохиргоо

Үндсэн Тохиргоо

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Тохиргоо > Принтерийн тохиргоо > Үндсэн Тохиргоо

Танай администратор түгжсэн тохиргоог та өөрчлөх боломжгүй.

LCD Гэрэлтэлт:

LCD дэлгэцийн цайралтыг тохируул.

Унтах Цаг тоологч:

Принтер ямар нэг үйлдэл хийгээгүй үед идэвхгүй горимд (эрчим хүч хэмнэх горим) шилжих хугацааг тохируулна уу. Тохируулсан хугацаа өнгөрсөний дараа LCD дэлгэц харлана.

Тэжээл унтраах цаг хэмжигч:

Худалдан авсан газраас хамааран таны бүтээгдэхүүнд энэ онцлог эсвэл **Унтраах Тохиргоо** онцлог байж болно.

Тодорхой хугацаанд ашиглаагүй үед энэ тохиргоог сонгож принтерийг автоматаар унтраана уу. Эрчим хүчний удирдлага хэрэгжих хүртэлх хугацааг тохируулах

Принтерийг бэлдэх

боломжтой. Энэ хугацааг ямарваа нэг хэмжээгээр ихэсгэх нь принтерийн эрчим хүчний хэмнэлтэд нөлөөлнө. Тиймээс ямар нэг өөрчлөлт хийхээс өмнө байгаль орчинд үзүүлэх нөлөөг нь тунгаан бодоорой.

Унтраах Тохиргоо:

Худалдан авсан газраас хамааран таны бүтээгдэхүүнд энэ онцлог эсвэл **Тэжээл унтраах цаг хэмжигч** онцлог байж болно.

☐ Идэвхгүй бол Унтраах

Хэрэв тодорхой хугацаанд ашиглаагүй бол энэ тохиргоог сонгож принтерийг автоматаар унтраана уу. Энэ хугацааг ямарваа нэг хэмжээгээр ихэсгэх нь принтерийн эрчим хүчний хэмнэлтэд нөлөөлнө. Тиймээс ямар нэг өөрчлөлт хийхээс өмнө байгаль орчинд үзүүлэх нөлөөг нь тунгаан бодоорой.

☐ Салгагдсан бол Унтраах

USB порт зэрэг бүх порт салгагдсанаас хойш заасан хугацааны дараа принтерийг унтраахын тулд энэ тохиргоог сонгоно уу. Энэ онцлог таны бүсээс хамаараад байхгүй байж болно.

Заасан хугацааны тухайд дараах вэбсайтаас үзнэ үү.

<https://www.epson.eu/energy-consumption>

Огноо/Цагийн Тохиргоо:

☐ Огноо/Цаг

Одоогийн цаг, огноог оруулна.

☐ Өдрийн гэрэлд хэмнэх цаг

Өөрийн бүсийн зуны цагийн тохиргоог сонгоно.

☐ Цагийн зөрүү

Орон нутгийн цаг болон UTC (Үндсэн Цагийн Бүс)-ийн хоорондох цагийн зөрүүг оруулна.

Хэл/Language:

LCD дэлгэцэнд ашиглагдсан хэлийг сонгоно.

Үйлдлийн Хугацаа Дуусах:

Тодорхой хугацаанд ашиглаагүй үед **Асс.** сонгож эхний дэлгэц рүү буцна уу. Хэрэглэгчийн хязгаарлалт хийгдэж, тодорхой хугацаанд үйлдэл хийгдээгүй үед, та гарч эхлэл дэлгэц рүү буцна.

Гар:

LCD дэлгэц дээрх гарны зураглалыг өөрчилнө.

Холбогдох мэдээлэл

➔ 48 хуудас дээрх "Эрчим хүч хэмнэх"

➔ 22 хуудас дээрх "Тэмдэгтийг оруулах"

Принтерийн Тохиргоо

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Принтерийг бэлдэх

Тохиргоо > Принтерийн тохиргоо > Принтерийн Тохиргоо

Танай администратор түгжсэн тохиргоог та өөрчлөх боломжгүй.

Цаасны Эхийн Тохиргоо:

Цаасны тохиргоо:

Цаасны эх үүсвэрт ачаалсан цаасныхаа хэмжээ болон төрлийг сонгоно.

Ар Цаас Татагч тэргүүн дараалал:

Асс. сонгож, арын цаасны дайз-д ачаалсан цаасанд хэвлэлтийн дарааллыг өгнө үү.

A4/Захидал Автоматаар Шилжих:

Асс. сонгож Letter хэмжээгээр тохируулсан цаасны эх үүсвэр байхгүй бол цаасыг A4 хэмжээгээр тохируулсан цаасны эх үүсвэрээс татах эсвэл, A4 хэмжээгээр тохируулсан цаасны эх үүсвэр байхгүй бол Letter хэмжээгээр тохируулсан цаасны эх үүсвэрээс татна.

Автомат Сонгох Тохиргоо:

Асс. сонгож, таны цаасны тохиргоотой таарч байвал ямар ч эх үүсвэрийн цаасан дээр автоматаар энэ тохиргоо хэвлэнэ.

Алдааны Мэдэгдэл:

Асс. сонгож, сонгосон цаасны хэмжээ эсвэл төрөл ачаалсан цаастай таарахгүй байгаа үед алдааны мессежийг харуул.

Цаасны тохиргоог автомат-р гаргах:

Цаасны эх үүсвэрт цаас ачаалах үед **Асс.** сонгож **Цаасны тохиргоо** дэлгэцийг харуул. Та энэ онцлогийг салгавал AirPrint ашиглан iPhone эсвэл iPad дээрээс хэвлэх боломжгүй.

Хэвлэх Хэл:

USB интерфейсийн хэвлэлтийн хэл эсвэл сүлжээний интерфейсийг сонгоно уу.

Хэвлэх Нэгдсэн Тохиргоо:

Эдгээр хэвлэх тохиргоонууд нь принтерийн драйверийг ашиглахгүйгээр гадаад төхөөрөмжөөр хэвлэх үед хэрэгжинэ. Оффсет тохиргоонууд нь принтерийн драйвер ашиглан хэвлэх үед хэрэгжинэ.

Дээд Зах:

Цаасны дээд захыг тааруулна.

Зүүн Зах:

Цаасны зүүн захыг тааруулна.

Арын дээд талын оффсет:

2-талт хэвлэлтийн үед, ар талын дээд захыг тааруулна.

Принтерийг бэлдэх

Зүүн дээд талын оффсет:

2-талт хэвлэлтийн үед, ар талын зүүн захыг тааруулна.

Цаасны Өргөнийг Шалгах:

Асс. сонгож хэвлэхийн өмнө цаасны өргөнийг шалгана уу. Ингэснээр цаасны хэмжээний тохиргоо буруу өгөгдсөн үед цаасны ирмэгээс хэтэрч хэвлэхээс сэргийлэх боловч хэвлэх хурд удааширч магадгүй.

Хоосон Хуудсын Алгасах:

Автоматаар хэвлэх өгөгдөл доторх хоосон хуудсыг алгасна.

PDL Хэвлэх Тохируулга:

Та PCL эсвэл PostScript хэвлэлтэнд зориулан ашиглахыг хүссэн PDL Хэвлэх Тохируулга сонголтыг сонгоно уу.

Түгээмэл Тохиргоонууд:

- ☐ Цаасны Хэмжээ
PCL болон PostScript хэвлэлтэнд зориулсан цаасны өгөгдмөл хэмжээг сонгоно уу.
- ☐ Цаасны Төрөл
PCL болон PostScript хэвлэлтэнд зориулсан цаасны өгөгдмөл төрлийг сонгоно уу.
- ☐ Чиглэл
PCL болон PostScript хэвлэлтэнд зориулсан өгөгдмөл чиглэлийг сонгоно уу.
- ☐ Чанар
PCL болон PostScript хэвлэлтэнд зориулсан хэвлэлтийн чанарыг сонгоно уу.
- ☐ Хор хадгалах горим
Хэвлэлийн нягтралыг багасгаж хор хэмнэхийн тулд **Асс.** сонгоно уу.
- ☐ Хэвлэх Дараалал
Сүүлийн хуудсыг дээр
Файлын эхний хуудаснаас эхэлж хэвлэнэ.
Эхний хуудсыг дээр
Файлын сүүлийн хуудаснаас эхэлж хэвлэнэ.
- ☐ Хувийн тоо
Хэвлэх хувийн тоог тохируул.
- ☐ Үдэх зах
Нуруулдах байрлалыг сонгоно уу.
- ☐ Автомат цаас гаргалт
Хэвлэлт явагдаж байх үед хэвлэхээ болиход цаасыг автоматаар татахын тулд **Асс.** сонгоно уу.
- ☐ 2 талаар хэвлэх
2 талаар хэвлэхийн тулд **Асс.** сонгоно уу.

Принтерийг бэлдэх

PCL Цэс:

- ☐ Үсгийн хэвний эх үүсвэр

Суурин

Хэвлэгч дээр өмнө нь суулгасан үсгийн хэвээ ашиглахаар сонгоно уу.

Татаж авах

Татаж авсан үсгийн хэвээ ашиглахаар сонгоно уу.

- ☐ Үсгийн хэвний дугаар

Үсгийн хэвний өгөгдмөл эхэд үсгийн хэвний өгөгдмөл тоог сонгоно уу. Таны хийсэн тохируулгаас шалтгаалж боломжит тоо өөрчлөгдөнө.

- ☐ Түвшин

Үсгийн хэвийг багасгах эсвэл томруулах боломжтой болон өндрийг нь тохируулсан бол үсгийн хэвний өгөгдмөл өндөрт тохируулна уу. Та 0.01 өөрчлөлтөд 0.44 – 99.99 хүртэл cpi (инч бүр дэх тэмдэг) сонгож болно.

Үсгийн хэвний эх болон үсгийн хэвний тооны тохируулгаас шалтгаалж энэ зүйл харагдахгүй байх боломжтой.

- ☐ Өндөр

Үсгийн хэвийг томруулах эсвэл багасгах боломжтой мөн пропорциональ бол үсгийн хэвний өгөгдмөл өндрийг тохируулна уу. Та 0.25 өөрчлөлтөд 4.00 – 999.75 хүртэл цэг сонгож болно.

Үсгийн хэвний эх болон үсгийн хэвний тооны тохируулгаас шалтгаалж энэ зүйл харагдахгүй байх боломжтой.

- ☐ Тэмдэг тохируулах

Тэмдгийн өгөгдмөл тохируулгыг сонгоно уу. Хэрэв таны сонгосон үсгийн хэв болон үсгийн хэвийн дугаарын тохиргоо шинэ тэмдэг тохируулах тохиргоонд боломжгүй байвал үсгийн хэвийн эх үүсвэр болон үсгийн хэвийн дугаарын тохиргоо автоматаар өгөгдмөл утгаар солигдоно, IBM-US.

- ☐ Маягт

Сонгосон цаасны хэмжээ болон чиглэлийн зураасны тоог тохируулна уу. Энэ нь мөн зураасны зай (VMI) өөрчлөгдөхөд хүргэх ба шинэ VMI утга принтерт хадгалагдана. Энэ нь хуудсын хэмжээ болон чиглэлийн тохиргоонд гарсан дараа дараагийн өөрчлөлтүүд хадгалагдсан VMI-д тулгуурласан Маягтын утгыг мөн өөрчлөнө гэсэн үг.

- ☐ CR Функц

Тодорхой үйлдлийн системээс драйвер ашиглан хэвлэх үед зураасны тэжээлийн командыг сонгоно уу.

- ☐ LF Функц

Тодорхой үйлдлийн системээс драйвер ашиглан хэвлэх үед зураасны тэжээлийн командыг сонгоно уу.

- ☐ Цаасны эх үүсвэр оноох

Цаасны эх үүсвэрийг сонгох командын даалгаварыг тохируулна уу. **4** сонгогдсон үед командууд HP LaserJet 4-тай таарч тохируулагдана. **4K** сонгогдсон үед командууд HP LaserJet 4000, 5000, 8000-тай таарч тохируулагдана. **5S** сонгогдсон үед командууд HP LaserJet 5S-тай таарч тохируулагдана.

Принтерийг бэлдэх

PS3 Цэс:

- ☐ Алдааны хуудас

Асс. сонгож PostScript эсвэл PDF хэвлэлтийн үед алдаа гарвал төлөвийг харуулсан хуудсыг хэвлэнэ үү.

- ☐ Өнгөжүүлэх

PostScript хэвлэлтэд өнгийн төлөвийг сонгоно уу.

- ☐ Хос

Хос дүрслэл бүхий өгөгдөл хэвлэх үед **Асс.** сонгоно уу. Хэвлэгчийн драйвер тохиргоо ASCII руу тохируулагдсан байсан ч энэ программ хос өгөгдөл илгээж болох ба энэ онцлог идэвхжсэн үед та өгөгдлөө хэвлэх боломжтой.

- ☐ PDF цаасны хэмжээ

PDF файл хэвлэх үед цаасны хэмжээг сонгоно. **Автомат** сонгогдсон бол цаасны хэмжээ эхний хуудасны хэмжээнд үндэслэн тодорхойлогдоно.

Автомат Алдаа Ялгагч:

2 талаар хэвлэхэд алдаа гарсан эсвэл санах ой дүүрэн гэсэн алдаа гарсан үед гүйцэтгэх үйлдлийг сонгоно.

- ☐ Асс.

2 талаар хэвлэхэд алдаа гарсан эсвэл санах ой дүүрэн гэсэн алдаа гарахад зөвхөн принтерийн боловсруулж чадах хэмжээнд зөвхөн хэвлэх үед анхааруулга харуулж, нэг талт горимоор хэвлэнэ.

- ☐ Офф

Алдааны мессежийг харуулж хэвлэлтийг цуцлана.

Зузаан Цаас:

Асаах сонговол бэх таны хэвлэлтийг бохирдуулахаас сэргийлнэ, гэхдээ энэ хэвлэлтийн хурдыг бууруулж болзошгүй.

Чимээгүй горим:

Асс. сонгож хэвлэх үеэр дуу чимээг бууруулна уу, гэхдээ энэ хэвлэлтийн хурдыг бууруулж болзошгүй. Таны сонгосон цаасны төрөл ба хэвлэлтийн чанарын тохиргооноос хамаарч, хэвлэгчийн оновчлолын түвшинд ялгаа гарахгүй байж болзошгүй.

Хор хатах хугацаа:

2 талаар хэвлэх үед ашиглахыг хүссэн бэхний хатах хугацааг сонгоно. Принтер нэг талыг хэвлэсний дараа нөгөө тал дээр нь хэвлэнэ. Хэрэв таны хэвлэлт бохирдсон байвал цагийн тохиргоог өсгөнө үү.

USB-ээрх PC холболт:

Идэвхжүүлэх сонгож, USB-р холбогдсон үед принтерт хандахыг компьютерт зөвшөөрнө үү. **Идэвхигүй болгох** сонгогдсон үед сүлжээний холболтоор илгээгдээгүй хэвлэх үйлдэл хязгаарлагдана.

USB I/F Цаг дуусах Хугацаа:

Принтер хэвлэх ажлыг PostScript принтерийн драйвер эсвэл PCL принтерийн драйвераас хүлээн авсаны дараа USB компьютертой холбоо тогтоохыг дуусгахын өмнө засварлах хугацааг зааж өгнө үү. Ажлын гүйцэтгэл PostScript принтерийн драйвер

Принтерийг бэлдэх

эсвэл PCL принтерийн драйвераас тодорхой заагдаагүй бол хязгааргүй USB харилцаа холбоог үүсгэж болзошгүй. Ийм зүйл болвол тодорхой хугацаа өнгөрсөний дараа принтер холболтоо дуусгана. Холболтыг дуусгахыг хүсэхгүй байгаа бол 0 (тэг) оруул.

Холбогдох мэдээлэл

➔ [25 хуудас дээрх "Цаасуудыг ачаалах"](#)

Сүлжээний тохиргоо

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Тохиргоо > Принтерийн тохиргоо > Сүлжээний тохиргоо

Танай администратор түгжсэн тохиргоог та өөрчлөх боломжгүй.

Wi-Fi Тохируулга:

Утасгүй сүлжээний тохиргоог тохируулж өөрчилнө үү. Дараахаас холболтын аргыг сонгож, дараа нь LCD самбар дээрх зааврыг дагана уу.

- ☐ Рүүтэр
- ☐ Wi-Fi Direct

Утастай LAN тохируулга:

LAN кабель эсвэл роутер ашигладаг сүлжээний холболтыг тохируулж өөрчилнө үү. Үүнийг ашиглах үед Wi-Fi холболт сална.

Сүлжээний Статус:

Одоогийн сүлжээний тохиргоог харуулах буюу хэвлэнэ.

- ☐ Утастай LAN/Wi-Fi төлөв
- ☐ Wi-Fi Direct төлөв
- ☐ Төлөвийн Хуудсыг Хэвлэх

Холболтыг Шалгах:

Одоогийн сүлжээний холболтыг шалгаж тайлан мэдээг хэвлэнэ. Холболтод ямар нэг асуудал гарсан бол, асуудлыг шийдэхийн тулд тайланг үзнэ үү.

Нэмэлт:

Дараах нарийн тохиргоог хийнэ үү.

- ☐ Төхөөрөмжийн нэр
- ☐ TCP/IP
- ☐ Прокси Сервер
- ☐ IPv6 Хаяг
- ☐ Холбоосын хурд ба дуплекс
- ☐ HTTP-г HTTPS рүү дамжуулах
- ☐ IPsec/IP шүүлтийг идэвхгүй болгох

Принтерийг бэлдэх

- ☐ IEEE802.1X-г идэвхгүй болгох
- ☐ iBeacon дамжуулалт

Вэб үйлчилгээний тохиргоо

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Тохиргоо > Принтерийн тохиргоо > Вэб үйлчилгээний тохиргоо

Танай администратор түгжсэн тохиргоог та өөрчлөх боломжгүй.

Epson Холболт Үйлчилгээ:

Принтер Epson Connect-д бүртгэгдэж холбогдсон эсэхийг харуулна.

Та **Бүртгүүлэх** товшиж үйлчилгээнд бүртгүүлж зааврыг дагана уу.

Та бүртгүүлсэнийхээ дараа дараах тохиргоог өөрчилж болно.

- ☐ Саатуулах/Дахин сэргээх
- ☐ Бүртгэлээс хасах

Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол дараах вэбсайтыг үзнэ үү.

<https://www.epsonconnect.com/>

<http://www.epsonconnect.eu> (Зөвхөн Европод)

Google Cloud Print үйлчилгээ:

Принтер Google Cloud Print үйлчилгээнд бүртгэгдэж холбогдсон эсэхийг харуулна.

Та бүртгүүлсэнийхээ дараа дараах тохиргоог өөрчилж болно.

- ☐ Идэвхжүүлэх/Идэвхгүй болгох
- ☐ Бүртгэлээс хасах

Google Cloud Print үйлчилгээнд бүртгүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бол дараах вэбсайтыг үзнэ үү.

<https://www.epsonconnect.com/>

<http://www.epsonconnect.eu> (Зөвхөн Европод)

Системийн Удирдлага-н цэсийн сонголтууд

Энэ цэсийг ашиглан та бүтээгдэхүүнийг системийн администратороор болгох боломжтой. Мөн энэ нь бүтээгдэхүүний онцлогийг ажил эсвэл оффисын загварт тохируулж нэг хэрэглэгчээр хазгаарлах боломж олгоно.

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Тохиргоо > Принтерийн тохиргоо > Системийн Удирдлага

Дотоод Санах ойг Арилгах:

PCL эсвэл PostScript нийцтэй принтер дээр зүйл гарч ирнэ.

Принтерийг бэлдэх

Татаж авсан үсгийн хэв, PCL хэвлэх макро зэрэг принтерийн дотоод санах ойн өгөгдлийг устга.

Хамгаалалтын тохиргоо:

Та дараах хамгаалалтын тохиргоог хийх боломжтой.

Бүх Нууцлалтай Ажлыг Устгах

Принтер лүү илгээсэн бүх нууцлалтай ажлуудыг устгах.

Админ тохиргоо:

☐ Админы Нууц үг

Администраторын нууц үгийг тохируулж, өөрчлөх буюу устгана.

☐ Тохиргоог түгжих

Админы Нууц үг дээр бүртгэгдсэн нууц үгийг ашиглан хянах самбарыг түгжих эсэхээ сонгоно.

Өгөгдмөл тохиргоог сэргээх:

Дараах цэсэнд байгаа тохиргоог өгөгдмөл болгон буцаана.

☐ Сүлжээний тохиргоо

☐ Сүлжээний тохиргооноос бусад бүх

☐ Бүх тохиргоо

Фирмварийн шинэчлэл:

Та сүүлийн үеийн загвар болон боломжит шинэчлэл дэх мэдээлэл зэрэг техник хангамжийн мэдээллийг авах боломжтой.

Шинэчлэх:

Программ хангамжийн хамгийн сүүлийн үеийн хувилбар сүлжээний серверт байршсан эсэхийг шалга. Шинэчлэлт байгаа бол шинэчлэж эхлэх эсэхээ сонго.

Мэдэгдэл:

Асс. сонгож техник хангамжийн шинэчлэлт байвал мэдэгдлийг хүлээн ав.

Хэвлэлт тоолуур-н цэсийн сонголтууд

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Тохиргоо > Хэвлэлт тоолуур

Принтерийг худалдаж авсанаас хойшхи Х ба Ц, өнгөт хэвлэлтүүд, үүний дотор хуудасны төлөв зэрэг зүйлсүүдийг, бүх хэвлэлтийн тоог харуулна. Үр дүнг нь хэвлэхийг хүсвэл **Хэвлэх хуудас** сонго.

Хангамжийн төлөв-н цэсийн сонголтууд

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонгоно уу.

Принтерийг бэлдэх

Тохиргоо > Хангамжийн төлөв

Засвар үйлчилгээний хайрцагны барагцаалсан бэхний түвшин, үйлчилгээний хугацааг харуулна.

! гарч ирвэл хор дуусаж, засвар үйлчилгээний хайрцаг бараг дүүрсэн гэсэн үг. Хэрэв ✗ гарч ирвэл бэх зарцуулагдаж, засвар үйлчилгээний хайрцаг дүүрсэн тул солих хэрэгтэй.

Засвар үйлчилгээ-н цэсийн сонголтууд

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Тохиргоо > Засвар үйлчилгээ

Хэвлэх чанар тааруулах:

Таны хэвлэлтэнд ямар нэг асуудал гарвал энэ онцлогийг сонгоно уу. Та бөглөрсөн хошууг шалгаж, шаардлагатай бол принтерийн толгойг цэвэрлэж, дараа нь хэвлэлтийн чанарыг сайжруулахын тулд зарим параметрийг тохируулж болно.

Хэвлэх Толгой Хошуу Шалгах:

Хэвлэх толгойн хошуу бөглөрсөн эсэхийг шалгах бол энэ онцлогийг сонгоно уу. Принтер хошуу шалгах хээг хэвлэнэ.

Хэвлэх Толгойг Цэвэрлэх:

Хэвлэх толгойн бөглөрсөн хошууг цэвэрлэх бол энэ онцлогийг сонгоно уу.

Шугамтай зураасыг зэрэгцүүлэх:

Босоо шугамыг эгнүүлэх бол энэ онцлогийг сонгоно уу.

Цаас заагчийг цэвэрлэх:

Доторх өнхөлүүр дээр бэхний толбо байвал энэ онцлогийг сонгоно уу. Принтер доторх өнхөлүүрийг цэвэрлэхийн тулд цаасыг ачаална.

Цаас тус бүрийн Хэвлэх чанар тааруулах:

Цаасны төрлөөс хамаарч бэхний онцлог ялгаатай байна. Хэвлэлтэнд судал үүссэн эсвэл тодорхой нэг цаасны төрөлд тэгш бус шугам үүссэн байвал энэ онцлогийг сонгоно уу.

Тогтмол цэвэрлэгээ:

Принтер тодорхой цаг хугацаанд суурилан **Хэвлэх Толгой Хошуу Шалгах** ба **Хэвлэх Толгойг Цэвэрлэх**-ийг автоматаар гүйцэтгэнэ. Дээд зэргээр хэвлэх чанарыг хадгалахын тулд **Асс.**-ийг сонго.

Холбогдох мэдээлэл

- ➔ 152 хуудас дээрх "Хэвлэлтийн чанарыг тохируулах"
- ➔ 125 хуудас дээрх "Принтерийн толгойг шалгаж цэвэрлэх"
- ➔ 127 хуудас дээрх "Шугамтай зураасуудыг тэгшлэх"
- ➔ 127 хуудас дээрх "Цаасны зам дахь бэхний өнгөрийг цэвэрлэх"

Принтерийг бэлдэх

Хэл/Language-н цэсийн сонголтууд

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Тохиргоо > Хэл/Language

LCD дэлгэцэнд ашиглагдсан хэлийг сонгоно.

Принтерийн төлөв/Хэвлэлт-н цэсийн сонголтууд

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Тохиргоо > Принтерийн төлөв/Хэвлэлт

Статус Хуудсыг Хэвлэх:

Тохируулгын Статус Хуудас:

Принтерийн одоогийн төлөв болон тохиргоог харуулсан мэдээллийн хуудсуудыг хэвлэнэ.

Нөөцийн Статус Хуудас:

Зарцуулах нөөцийн төлөвийг харуулсан мэдээллийн хуудсуудыг хэвлэнэ.

Ашиглалтын Түүхийн Хуудас:

Принтерийн ашиглалтын түүхийг харуулсан мэдээллийн хуудсуудыг хэвлэнэ.

PS3 үсгийн хэвийн жагсаалт:

PostScript принтерт боломжтой үсгийн хэвүүдийн жагсаалтыг хэвлэнэ үү.

PCL Үсгийн хэвийн жагсаалт:

PCL принтерт боломжтой үсгийн хэвүүдийн жагсаалтыг хэвлэнэ үү.

Сүлжээ:

Одоогийн сүлжээний тохиргоог харуулна.

Баталгаажуулах төхөөрөмжийн төлөв-н цэсийн сонголтууд

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Тохиргоо > Баталгаажуулах төхөөрөмжийн төлөв

Баталгаажуулах төхөөрөмжийн төлөвийг харуулна.

Epson Open Platform-ын мэдээлэл-н цэсийн сонголтууд

Доор зааснаар хянах самбар дээрх цэсийг сонго.

Тохиргоо > Epson Open Platform-ын мэдээлэл

Epson нээлттэй платформын төлөвийг харуулна.

Эрчим хүч хэмнэх

Хэсэг хугацааны турш ямарваа ажиллагаа явагдаагүй бол принтер унтах горимд орж автоматаар унтарна. Эрчим хүчний удирдлага хэрэгжих хүртэлх хугацааг тохируулах боломжтой. Энэ хугацааг ямарваа нэг хэмжээгээр ихэсгэх нь принтерийн эрчим хүчний хэмнэлтэд нөлөөлнө. Тиймээс ямар нэг өөрчлөлт хийхээс өмнө байгаль орчинд үзүүлэх нөлөөг нь тунгаан бодоорой.

Эрчим хүч хэмнэх — Хянах самбар

1. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.

2. **Принтерийн тохиргоо > Үндсэн Тохиргоо**-г сонгоно.

3. Дараах үйлдлүүдийн аль нэгийг хий.

☐ **Унтах Цаг тоологч** эсвэл **Унтраах Тохиргоо > Идэвхгүй бол Унтраах** эсвэл **Салгагдсан бол Унтраах**-ийг сонгосны дараа тохиргоог хийнэ.

☐ **Унтах Цаг тоологч** эсвэл **Тэжээл унтраах цаг хэмжигч**-ийг сонгосны дараа тохиргоог хийнэ.

Тэмдэглэл:

Үйлдвэрлэсэн огноо, худалдан авсан газраас хамааран таны бүтээгдэхүүнд **Унтраах Тохиргоо** эсвэл **Тэжээл унтраах цаг хэмжигч** тохиргоо байж магадгүй.

Сүлжээний тохиргоо


Сүлжээний холболтын төрлүүд

Та дараах холболтын аргуудыг ашиглаж болно.

Ethernet-н холболт

Принтерийг Ethernet кабель ашиглан төвтэй холбоно.

Хөдөлгөөнгүй IP хаягийг тогтоохын туд *Администраторын Заавар*-ийг харна уу.




Холбогдох мэдээлэл

➔ [65 хуудас дээрх "Сүлжээний ахисан түвшний тохиргоо хийх"](#)

Wi-Fi холболт

Принтер, компьютер, ухаалаг төхөөрөмжөө утасгүй роутерт холбо. Энэ нь компьютерууд утасгүй роутерээр дамжуулж Wi-Fi-аар холбогдсон байдаг гэр, оффисын сүлжээний холболтын ердийн арга юм.




Холбогдох мэдээлэл

- ➔ 51 хуудас дээрх "Компьютертай холбогдох"
- ➔ 52 хуудас дээрх "Ухаалаг төхөөрөмжтэй холбох"
- ➔ 61 хуудас дээрх "Принтерээс Wi-Fi тохиргоог хийх"

Wi-Fi Direct (Энгийн AP) холболт

Та ажил болон гэртээ Wi-Fi ашиглахгүй байгаа үедээ эсвэл принтер компьютер болон ухаалаг төхөөрөмжийг шууд холбохыг хүсвэл энэ холболтын аргыг ашиглаарай. Энэ горимд принтер нь утасгүй роутерийн үүргийг гүйцэтгэх ба стандарт утасгүй роутерийг ашиглахгүйгээр принтерт төхөөрөмжүүд холбох боломжтой. Хэдийгээр төхөөрөмжүүд нь принтерт шууд холбогдсон ч принтерээр дамжин бие биетэйгээ холбогдож чадахгүй.



Принтер нь Wi-Fi буюу Ethernet болон Wi-Fi Direct (Энгийн AP) холболтоор зэрэг холбогдсон байх боломжтой. Гэхдээ, хэрэв та Wi-Fi Direct (Энгийн AP) холболтоор сүлжээний холболтыг эхлүүлбэл, принтер Wi-Fi-р холбогдох үед Wi-Fi-г түр салгана.

Холбогдох мэдээлэл

- ➔ 52 хуудас дээрх “Wi-Fi Direct ашиглан iPhone, iPad, iPod touch руу холбогдох”
- ➔ 55 хуудас дээрх “Android төхөөрөмжүүд рүү Wi-Fi Direct-г ашиглан холбогдох”
- ➔ 58 хуудас дээрх “iOS болон Android-с бусад төхөөрөмжийг Wi-Fi Direct-г ашиглан холбох”

Компьютертай холбогдох

Бид компьютерт принтерийг холбоход суулгагчийг ашиглахыг санал болгодог. Та дараах суулгагчийн аргуудын нэгийг ашиглан суулгах боломжтой.

☐ Вэбсайтаас тохируулах

Дараах вэбсайтаас нэвтэрч бүтээгдэхүүний нэрээ оруулна уу. **Тохируулга** орж, дараа нь суурилуулж эхэл.

<http://epson.sn>


☐ Программ хангамжийн диск ашиглан суулгах (зөвхөн диск драйвтай Windows компьютертой хэрэглэгч болон программ хангамжийн дисктэй загваруудад зориулагдсан)

Компьютерт программ хангамжийн дискийг оруулаад дэлгэцэн дээрх зааварчилгааг дага.

Холболтын аргуудыг сонгох

Дараахыг дэлгэцэн дээр харуулах хүртэл дэлгэцэн дээрх зааварчилгааг дагаад компьютерт принтерийг холбох аргыг сонго.

Холболтын төрлийг сонгоод **Дараах** товш.



Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Ухаалаг төхөөрөмжтэй холбох

Утасгүй роутерээр дамжуулан ухаалаг төхөөрөмжтэй холбох

Та ухаалаг төхөөрөмжийг холбосонтойгоо адилхан Wi-Fi сүлжээ (SSID)-д принтерийг холбосон бол ухаалаг төхөөрөмжөөс принтерийг ашиглах боломжтой. Ухаалаг төхөөрөмжөөс принтерийг ашиглахын тулд дараах вэбсайтаас суулгана уу. Та принтерээ холбохыг хүсэж байгаа ухаалаг төхөөрөмжөөсөө вэбсайтанд нэвтэрнэ үү.

<http://epson.sn> > **Тохируулга**

Тэмдэглэл:

Та компьютер болон ухаалаг төхөөрөмжөө нэгэн зэрэг Принтерт холбохыг хүсэж байвал эхлээд компьютероо холбохыг бид зөвлөж байна.

Холбогдох мэдээлэл

➔ [114 хуудас дээрх "Ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх"](#)

Wi-Fi Direct ашиглан iPhone, iPad, iPod touch руу холбогдох

Энэ арга нь утасгүй роутергүйгээр принтерийг iPhone, iPad, iPod touch руу шууд холбохыг танд зөвшөөрнө. Энэ функцийг ашиглахын тулд дараах нөхцлүүд шаардлагатай. Хэрэв таны орчин эдгээр нөхцөлүүдтэй нийцэхгүй байвал та **Бусад ҮС-төхөөрөмж**-г сонгон холбогдож болно. Холбох талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бол доорх холбогдох мэдээллийн холбоосыг харна уу.

- ☐ iOS 11 эсвэл дараах
- ☐ Стандарт камерын програмыг ашиглан QR кодыг скан хийнэ
- ☐ Epson iPrint хувилбар 7.0 эсвэл дараах

Epson iPrint-ийг ухаалаг төхөөрөмжөөс хэвлэхэд ашигладаг. Ухаалаг төхөөрөмж дээр Epson iPrint-г урьдчилан суурилуул.


Тэмдэглэл:

Та зөвхөн нэг л удаа холбогдохыг хүссэн принтер болон ухаалаг төхөөрөмж дээр эдгээр тохиргоог хийх хэрэгтэй. Wi-Fi Direct-ийг салгаж эсвэл сүлжээний тохиргоог өгөгдмөл болгон сэргээгээгүй л бол та эдгээр тохиргоог дахин хийх шаардлагагүй.


Сүлжээний тохиргоо

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.



2. **Wi-Fi Direct**-ийг сонго.
3. OK товчийг дарна уу.
4. **iOS**-ийг сонго.



Принтерийн хянах самбар дээр QR кодыг харуулсан байна.




Сүлжээний тохиргоо

5. Өөрийн iPhone, iPad, iPod touch дээрээс стандарт Камерын программыг ажиллуулж, дараа нь хэвлэгчийн хяналтын самбар дээр харуулсан QR кодыг ЗУРАГ горим дээрээс уншуулна уу.




iOS 11 эсвэл дараах хувилбарт зориулсан камерын програмыг ашиглана уу. Та iOS 10 эсвэл түүнээс өмнөх Камерын програмыг ашиглан принтертэй холбогдож болохгүй. Та мөн QR кодыг сканердахад зориулсан програмыг ашиглан холбогдож болохгүй. Хэрэв холбогдож чадахгүй байвал, принтерийн хянах самбарын дэлгэцийг гүйлгэж **Бусад ҮС-төхөөрөмж** сонго. Холбох талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бол доорх холбогдох мэдээллийн холбоосыг харна уу.

6. iPhone, iPad, iPod touch-ийн дэлгэцэн дээр харуулсан мэдэгдэл дээр дарна.



7. **Нэгдэх**-ийг товш.



8. Принтерийн хянах самбар дээрээс **Дараах**-г сонго.
9. iPhone, iPad, iPod touch дээрээс Epson хэвлэх программыг эхлүүлнэ.
Epson хэвлэх программын жишээнүүд



Epson iPrint




Epson Creative
Print

Сүлжээний тохиргоо

10. Epson хэвлэх программын дэлгэц дээрээс **Printer is not selected.**-г дарна.
11. Холбогдохыг хүсэж буй принтерийг сонгоно уу.



Принтерийг сонгохын тулд принтерийн хяналтын самбар дээр харуулсан мэдээллийг харна уу.



12. Принтерийн хянах самбар дээрээс **Дуусгах**-г сонго.

Өмнө нь принтер лүү холбогдож байсан ухаалаг төхөөрөмжүүдийн хувьд, дахин холбогдохын тулд ухаалаг төхөөрөмжийн Wi-Fi дэлгэцэн дээрх сүлжээний нэрийг (SSID) сонгоно уу.

Холбогдох мэдээлэл

- ➔ 58 хуудас дээрх "iOS болон Android-с бусад төхөөрөмжийг Wi-Fi Direct-г ашиглан холбох"
- ➔ 114 хуудас дээрх "Ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх"

Android төхөөрөмжүүд рүү Wi-Fi Direct-г ашиглан холбогдох

Энэ арга нь утасгүй роутергүйгээр принтерийг таны Android төхөөрөмжүүдэд шууд холбохыг танд зөвшөөрнө. Энэ функцийг ашиглахын тулд дараах нөхцлүүд шаардлагатай.

- ☐ Android 4.4 эсвэл дараах
- ☐ Epson iPrint хувилбар 7.0 эсвэл дараах

Сүлжээний тохиргоо


Epson iPrint-ийг ухаалаг төхөөрөмжөөс хэвлэхэд ашигладаг. Ухаалаг төхөөрөмж дээр Epson iPrint-г урьдчилан суурилуул.

Тэмдэглэл:


Та зөвхөн нэг л удаа холбогдохыг хүссэн принтер болон ухаалаг төхөөрөмж дээр эдгээр тохиргоог хийх хэрэгтэй. Wi-Fi Direct-ийг салгаж эсвэл сүлжээний тохиргоог өгөгдмөл болгон сэргээгээгүй л бол та эдгээр тохиргоог дахин хийх шаардлагагүй.

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.



2. **Wi-Fi Direct**-ийг сонго.
3. OK товчийг дарна уу.
4. **Android**-ийг сонго.



5. Ухаалаг төхөөрөмжөөс, Epson iPrint-г эхлүүлэх.




6. Epson iPrint дэлгэц дээр **Printer is not selected.**-г товш.

Сүлжээний тохиргоо

7. Холбогдохыг хүсэж буй принтерийг сонгоно уу.



Принтерийг сонгохын тулд принтерийн хяналтын самбар дээр харуулсан мэдээллийг харна уу.



Тэмдэглэл:

Android төхөөрөмжөөс шалтгаалан принтер харагдахгүй байж болно. Хэрэв принтер харагдахгүй бол, **Бусад ҮС-төхөөрөмж**-г сонгож холбогдох. Холбох талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бол доорх холбогдох мэдээллийн холбоосыг харна уу.

8. Төхөөрөмж холбохыг зөвшөөрөх дэлгэц гарах үед **Зөвшөөрөх**-г сонгоно уу.
9. Төхөөрөмжийн бүртгэлийн баталгаажуулалтын дэлгэц гарах үед зөвшөөрсөн төхөөрөмжийг принтер лүү бүртгэх эсэхээ сонго.
10. Принтерийн хянах самбар дээрээс **Дуусгах**-г сонго.

Өмнө нь принтер лүү холбогдож байсан ухаалаг төхөөрөмжүүдийн хувьд, дахин холбогдохын тулд ухаалаг төхөөрөмжийн Wi-Fi дэлгэцэн дээрх сүлжээний нэрийг (SSID) сонгоно уу.

Холбогдох мэдээлэл

- ➔ 58 хуудас дээрх "iOS болон Android-с бусад төхөөрөмжийг Wi-Fi Direct-г ашиглан холбох"
- ➔ 114 хуудас дээрх "Ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх"

iOS болон Android-с бусад төхөөрөмжийг Wi-Fi Direct-г ашиглан холбох


Энэ арга нь утасгүй роутергүйгээр принтерийг ухаалаг төхөөрөмжүүдэд шууд холбохыг танд зөвшөөрнө.

Тэмдэглэл:


Та зөвхөн нэг л удаа холбогдохыг хүссэн принтер болон ухаалаг төхөөрөмж дээр эдгээр тохиргоог хийх хэрэгтэй. Wi-Fi Direct-ийг салгаж эсвэл сүлжээний тохиргоог өгөгдмөл болгон сэргээгээгүй л бол та эдгээр тохиргоог дахин хийх шаардлагагүй.

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.




2. **Wi-Fi Direct**-ийг сонго.
3. OK товчийг дарна уу.
4. **Бусад ҮС-төхөөрөмж**-ийг сонго.



Принтерийн Wi-Fi Direct-н Сүлжээний нэр(SSID) болон Нууц үг-ийг харуулсан байна.

Сүлжээний тохиргоо

5. Ухаалаг төхөөрөмжийн Wi-Fi дэлгэц дээрээс принтерийн хяналтын самбар дээр харуулсан SSID-г сонгоод, нууц үг оруулна уу.



6. Принтерийн хянах самбар дээрээс **Дараах**-г сонго.

Сүлжээний тохиргоо

7. Ухаалаг төхөөрөмж дээрээс Epson хэвлэх программыг эхлүүлнэ үү.

Epson хэвлэх программын жишээнүүд



Epson iPrint




Epson Creative
Print

8. Epson хэвлэх программын дэлгэц дээрээс **Printer is not selected.**-г дарна.
9. Холбогдохыг хүсэж буй принтерийг сонгоно уу.



Принтерийг сонгохын тулд принтерийн хяналтын самбар дээр харуулсан мэдээллийг харна уу.



10. Принтерийн хянах самбар дээрээс **Дуусгах**-г сонго.

Өмнө нь принтер лүү холбогдож байсан ухаалаг төхөөрөмжүүдийн хувьд, дахин холбогдохын тулд ухаалаг төхөөрөмжийн Wi-Fi дэлгэцэн дээрх сүлжээний нэрийг (SSID) сонгоно уу.

Холбогдох мэдээлэл

➔ [114 хуудас дээрх "Ухаалаг төхөөрөмжөөс хэвлэх"](#)

Принтерээс Wi-Fi тохиргоог хийх

Та принтерийн хянах самбараас хэд хэдэн аргаар сүлжээний тохиргоог хийх боломжтой. Таны ашиглаж буй орчин нөхцөл байдалтай тохирч байгаа холболтын аргыг товш.

Хэрэв та утасгүй роутерийн мэдээлэл болох SSID, нууц үг зэргийг мэддэг бол тохиргоог гараар хийх боломжтой.

Хэрэв утасгүй роутер WPS дэмждэг бол та түлхэх товчны тохиргоо ашиглан тохиргоог хийх боломжтой.

Принтерийг сүлжээнд холбосны дараа хэрэглэхийг хүсэж байгаа төхөөрөмжөөсөө принтерийг холбо (компьютер, ухаалаг төхөөрөмж, таблет гэх мэт)

Хөдөлгөөнгүй IP хаяг ашиглан сайжруулсан сүлжээний тохиргоо хий.

Холбогдох мэдээлэл


- ➔ [61 хуудас дээрх "SSID болон нууц үгээ оруулж Wi-Fi тохиргоог хийх"](#)
- ➔ [63 хуудас дээрх "Түлхэх товчийг тохируулж \(WPS\) Wi-Fi-н тохиргоог хийх"](#)
- ➔ [64 хуудас дээрх "PIN код оруулж Wi-Fi тохиргоог хийх \(WPS\)"](#)
- ➔ [65 хуудас дээрх "Сүлжээний ахисан түвшний тохиргоо хийх"](#)

SSID болон нууц үгээ оруулж Wi-Fi тохиргоог хийх

Та принтерийн хянах самбараас утасгүй роутер лүү холбогдохын тулд шаардлагатай мэдээллийг оруулж, Wi-Fi сүлжээг тохируулах боломжтой. Энэ аргыг ашиглан тохируулахын тулд танд утасгүй роутерийн SSID болон нууц үг хэрэгтэй.

Тэмдэглэл:


Хэрэв та өөрийн өгөгдмөл тохиргоотой утасгүй роутер ашиглах гэж байгаа бол шошгон дээр байгаа SSID болон нууц үгийг ашигла. Хэрэв та SSID болон нууц үгийг мэдэхгүй бол утасгүй роутерийг тохируулдаг хүнтэй холбогдох эсвэл утасгүй роутерт өгөгдсөн бичиг баримтыг хараарай.



Сүлжээний тохиргоо

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.



2. **Рүүтэр**-ийг сонго.

3. OK товчийг дарна уу.

Хэрэв сүлжээний холболтыг аль хэдийн тохируулсан бол холболтын дэлгэрэнгүй харагдана.

Wi-Fi холболт руу өөрчил. эсвэл **Тохиргоог өөрчлөх**-ийг товшиж тохиргоог өөрчилнө үү.

4. **Wi-Fi тохируулах цонх**-ийг сонго.

5. Утасгүй роутерийн SSID-г сонго.

Тэмдэглэл:

- ❑ Хэрэв таны холбогдохыг хүссэн SSID принтерийн хянах самбар дээр харагдахгүй байгаа бол жагсаалтыг шинэчлэхийн тулд ↻-ийг товш. Хэрэв одоог хүртэл үүнийг дэлгэцэнд харуулаагүй байгаа бол + -ийг сонгоод SSID-г шууд оруул.
- ❑ Хэрэв та сүлжээний нэрийг (SSID) мэдэхгүй бол мэдээлэл нь утасгүй роутерийн шошго дээр бичигдсэн эсэхийг шалгаарай. Хэрэв та өөрийн өгөгдмөл тохиргоотой утасгүй роутерийг ашиглах гэж байгаа бол шошгон дээр байгаа SSID-г ашигла. Хэрэв та ямар нэгэн мэдээлэл олж чадахгүй бол утасгүй роутертай холбоотой бичиг баримтыг үзээрэй.

6. Нууц үг оруулна уу.

Тэмдэглэл:

- ❑ Нууц үг дээр том жижиг үсгийг ялгаж бичнэ.
- ❑ Хэрэв та нууц үгийг мэдэхгүй бол мэдээлэл нь утасгүй роутерийн шошго дээр бичигдсэн эсэхийг шалгаарай. Шошго дээр, нууц үг нь "Network Key", "Wireless Password" гэж бичигдсэн байж болно. Хэрэв та өөрийн өгөгдмөл тохиргоотой утасгүй роутерийг ашиглах гэж байгаа бол шошгон дээр байгаа нууц үгийг ашигла.

7. Суурилуулж дуусангуутаа **Тохируулгыг эхлүүлэх** товш.

8. Дуусгахын тулд **Орхих** сонго.

Тэмдэглэл:

Хэрэв та холбогдож чадахгүй байгаа бол A4 хэмжээтэй хоосон цаасыг ачаалж, холболтын тайланг хэвлэх **Принтер шалгах тайлан** дээр товш.

9. Сүлжээний холболтын тохиргооны дэлгэцийг хаана уу.

Сүлжээний тохиргоо

Холбогдох мэдээлэл

- ➔ 22 хуудас дээрх "Тэмдэгтийг оруулах"
- ➔ 67 хуудас дээрх "Сүлжээний холболтын төлөвийг шалгах"
- ➔ 148 хуудас дээрх "Сүлжээний тохиргоо хийж чадахгүй бол"

Түлхэх товчийг тохируулж (WPS) Wi-Fi-н тохиргоог хийх

Та утасгүй роутер дээрх товчийг дарснаар Wi-Fi сүлжээг автоматаар тохируулах боломжтой. Дараах нөхцөл биелсэн бол, та энэхүү аргыг ашиглаж тохиргоо хийх боломжтой.


- ☐ Утасгүй роутер нь WPS (Wi-Fi-ийн хамгаалалттай тохиргоо)-тай нийцсэн байх.
- ☐ Утасгүй роутер дээрх товчийг дарснаар одоогийн Wi-Fi холболтыг тогтоосон.

Тэмдэглэл:

Та товчийг олохгүй эсвэл програм ашиглан тохиргоо хийж байгаа бол, утасгүй роутертэй цуг ирсэн баримт бичгийг үзнэ үү.

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.




2. **Рүүтэр**-ийг сонго.
3. OK товчлуурыг дарна.

Хэрэв сүлжээний холболтыг аль хэдийн тохируулсан бол холболтын дэлгэрэнгүй харагдана.
Wi-Fi холболт руу өөрчил. эсвэл **Тохиргоог өөрчлөх**-ийг товшиж тохиргоог өөрчилнө үү.

4. **Даралтат товчны тохируулга (WPS)**-ийг сонго.

Сүлжээний тохиргоо

5. Хамгаалалтын гэрэл анивчих хүртэл утасгүй роутер дээрх [WPS] товчийг удаан дарна.



Та [WPS] товчийг хаана байгааг мэдэхгүй байгаа бол, мөн утасгүй роутер дээр товч байхгүй бол, дэлгэрэнгүй мэдээллийг нэвтрэх цэгтэй цуг ирсэн баримт бичгээс үзнэ үү.

6. Принтер дээрх ОК товчийг дар.

7. Дэлгэцийг хаа.

Тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.

Тэмдэглэл:

Хэрэв холболт амжилтгүй болвол утасгүй роутерийг дахин эхлүүлж, үүнийг принтерт ойртуулж, дахин оролдоно уу. Хэрэв ажиллахгүй бол сүлжээний холболтын тайланг хэвлэж шийдлийг шалгана уу.

8. Сүлжээний холболтын тохиргооны дэлгэцийг хаана үү.

Холбогдох мэдээлэл

- ➔ 67 хуудас дээрх "Сүлжээний холболтын төлөвийг шалгах"
- ➔ 148 хуудас дээрх "Сүлжээний тохиргоо хийж чадахгүй бол"


PIN код оруулж Wi-Fi тохиргоог хийх (WPS)

Та PIN код ашиглан утасгүй роутертэй автоматаар холбогдох боломжтой. Утасгүй роутер нь WPS (Wi-Fi-н хамгаалалттай тохиргоо)-ийн чадавхитай бол та энэхүү аргыг тохиргоо хийхэд ашиглаж болно. Утасгүй роутерт PIN кодыг оруулахдаа компьютер ашиглана уу.

Сүлжээний тохиргоо

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.



2. **Рүүтэр**-ийг сонго.

3. OK товчийг дарна уу.

Хэрэв сүлжээний холболтыг аль хэдийн тохируулсан бол холболтын дэлгэрэнгүй харагдана.

Wi-Fi холболт руу өөрчил. эсвэл **Тохиргоог өөрчлөх**-ийг товшиж тохиргоог өөрчилнө үү.

4. **Бусад** > **PIN Код Тохиргуулга (WPS)**-г сонгоно

5. Принтерийн хянах самбар дээр харуулсан PIN код (8 оронтой тоо)-ыг утасгүй роутерт 2 минутын дотор оруулахдаа компьютероо ашигла.

Тэмдэглэл:

PIN код оруулах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг утасгүй роутертэй цуг ирсэн баримт бичгээс үзнэ үү.

6. Принтер дээрх OK товчийг дар.

7. Дэлгэцийг хаа.

Хэрэв та **Хаах** дээр дарахгүй бол тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.

Тэмдэглэл:

Хэрэв холболт амжилтгүй болвол утасгүй роутерийг дахин эхлүүлж, үүнийг принтерт ойртуулж, дахин оролдоно уу. Хэрэв ажиллахгүй бол холболтын тайланг хэвлэж шийдлийг шалгана уу.

8. Сүлжээний холболтын тохиргооны дэлгэцийг хаана уу.

Холбогдох мэдээлэл

➔ 67 хуудас дээрх "Сүлжээний холболтын төлөвийг шалгах"

➔ 148 хуудас дээрх "Сүлжээний тохиргоо хийж чадахгүй бол"

Сүлжээний ахисан түвшний тохиргоо хийх

Та сүлжээний төхөөрөмжийн нэр, TCP/IP тохиргоо, прокси сервер зэргийг өөрчлөх боломжтой.Өөрчлөлт хийхийн өмнө сүлжээний орчиноо шалгана уу.

Сүлжээний тохиргоо

1. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.

2. **Принтерийн тохиргоо > Сүлжээний тохиргоо > Нэмэлт**-г сонго.

3. Тохиргооны цэсийн зүйлийг сонгоод дараа нь тохиргооны утгыг сонгож тодорхой тусгана уу.

Холбогдох мэдээлэл

➔ [66 хуудас дээрх "Нарийн сүлжээний тохиргоонд зориулсан тохиргооны зүйлс"](#)

Нарийн сүлжээний тохиргоонд зориулсан тохиргооны зүйлс

Тохиргооны цэсийн зүйлийг сонгоод дараа нь тохиргооны утгыг сонгож тодорхой тусгана уу.

☐ Төхөөрөмжийн нэр

Та дараах тэмдэгтүүдийг оруулах боломжтой.

☐ Тэмдэгтийн хязгаар: 2–15 (та дор хаяж 2 тэмдэгт оруулах ёстой)

☐ Ашиглах боломжтой тэмдэгтүүд: A–Z, a–z, 0–9, -.

☐ Дээр ашиглах боломжгүй тэмдэгтүүд: 0–9.

☐ Доор ашиглах боломжгүй тэмдэгтүүд: -

☐ TCP/IP

☐ Автомат

Гэрийнхээ нэвтрэх цэгийг ашиглах гэснийг сонго эс бөгөөс та IP хаягийг автоматаар илрүүлэхийг зөвшөөрнө.

☐ Механик

Та принтерийнхээ IP хаягийг өөрчлөхийг хүсэхгүй бол сонго. IP хаяг, Дэд сүлжээний хүрээ, Өгөгдмөл гарц-н хаягуудыг оруулж, DNS Сервер-н тохиргоог өөрийн сүлжээний орчны дагуу хийнэ үү.

☐ Прокси Сервер

☐ Хэрэглэхгүй

Гэрийн сүлжээний орчинд принтер ашиглах эсэхийг сонго.

☐ Ашиглах

Та сүлжээний орчинд прокси сервер ашиглаж байгаа үүнийг принтерт тохируулахыг хүсэж байгаа эсэхээ сонго. Прокси серверийн хаяг ба портын дугаарыг оруул.

☐ IPv6 Хаяг

☐ Идэвхжүүлэх

Үүнийг IPv6 хаяг ашиглаж байгаа үед сонго.

☐ идэвхигүй болгох

Үүнийг IPv4 хаяг ашиглаж байгаа үед сонго.

Сүлжээний тохиргоо

☐ Холбоосын хурд ба дуплекс

Зохих Ethernet хурд, дуплекс тохиргоог сонгоно. Хэрэв та Автомат-с өөр тохиргоог сонговол таны ашиглаж байгаа тохиргоонд тохиргоо хамаарч байгаа эсэхийг баталгаажуул.

☐ Автомат

☐ 10BASE-T Нэг Чиглэлт

☐ 10BASE-T Хоёр Чиглэлт

☐ 100BASE-TX Нэг Чиглэлт

☐ 100BASE-TX Хоёр Чиглэлт

☐ HTTP-г HTTPS рүү дамжуулах

☐ Идэвхжүүлэх

HTTP — HTTPS-ийн эргэн шилжүүлэх функцийг идэвхжүүлнэ.

☐ идэвхигүй болгох

HTTP — HTTPS-ийн эргэн шилжүүлэх функцийг салгана.

☐ IPsec/IP шүүлтийг идэвхгүй болгох

Хамгаалалтын тохиргооны улмаас принтертэй холбогдож чадахгүй бол IPsec/IP шүүх функцийг салгана.

☐ IEEE802.1X-г идэвхгүй болгох

Хамгаалалтын тохиргооны улмаас принтертэй холбогдож чадахгүй бол IEEE 802.1X шүүх функцийг салгана.

☐ iBeacon Илгээлт

☐ Идэвхжүүлэх

iBeacon илгээх функцийг идэвхжүүлэх.

☐ идэвхигүй болгох

iBeacon илгээх функцийг салгах.

Сүлжээний холболтын төлөвийг шалгах

Та дараах байдлаар сүлжээний холболтын төлөвийн статусыг шалгах боломжтой.

Сүлжээний тэмдэг

Принтерийн нүүр дэлгэц дээр байгаа сүлжээний тэмдгийг ашиглан сүлжээний холболтын төлөв болон радио долгионы хүчийг шалгах боломжтой.



Сүлжээний тохиргоо

Холбогдох мэдээлэл

➔ 20 хуудас дээрх "LCD дэлгэц дээр харагдах тэмдгүүд"

Хянах самбараас Дэлгэрэнгүй сүлжээний мэдээллийг шалгах

Принтерийг сүлжээнд холбогдсоны дараа та шалгахыг хүссэн сүлжээний цэсийг сонгож бусад сүлжээтэй холбоотой мэдээллийг харах мөн боломжтой.

1. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.
2. **Принтерийн тохиргоо** > **Сүлжээний тохиргоо** > **Сүлжээний Статус**-г сонго.
3. Мэдээллийг шалгахын тулд шалгахыг хүссэн цэсүүдийг сонго.
 - ☐ Утастай LAN/Wi-Fi төлөв
Ethernet ба утасгүй интернэтийн холболтын сүлжээний мэдээллийг (төхөөрөмжийн нэр, холболт, дохионы хүчин чадал гэх мэт) харуулна.
 - ☐ Wi-Fi Direct төлөв
Wi-Fi Direct ба SSID, нууц үг, Wi-Fi Direct холболт идэвхжсэн эсвэл салсан эсэхийг харуулна.
 - ☐ Төлөвийн Хуудсыг Хэвлэх
Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэнэ. Ethernet, Wi-Fi, Wi-Fi Direct зэргийн мэдээлэл хоёр буюу түүнээс дээш хуудсан дээр хэвлэгдэнэ.

Сүлжээний холболтын тайланг хэвлэх

Та хэвлэгч ба утасгүй роутер хоорондын төлөвийг шалгахын тулд сүлжээний холболтын тайланг хэвлэх боломжтой.

1. Цаасаа ачаална.
2. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.
Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.
3. **Принтерийн тохиргоо** > **Сүлжээний тохиргоо** > **Холболтыг Шалгах**-г сонго.
Холболт шалгах эхэлнэ.
4. **Принтер шалгах тайлан**-ийг сонго.
5. Сүлжээний холболтын тайланг хэвлэ.
Хэрэв алдаа заавал сүлжээний холболтын тайланг шалгаад хэвлэсэн шийдлийг дагана уу.
6. Дэлгэцийг хаа.

Холбогдох мэдээлэл

➔ 69 хуудас дээрх "Сүлжээний холболтын тайлан дахь мессеж болон гарцууд"

Сүлжээний тохиргоо

Сүлжээний холболтын тайлан дахь мессеж болон гарцууд

Сүлжээний холболтын тайланд гарч буй мессежүүд болон алдаа заалтуудыг харан алдааг шийдвэрлэх гарцыг дагах.

Check Network Connection

Check Result: FAIL

Error code: (E-2)

See the Network Status and check if the Network Name (SSID) is the SSID you want to connect. If the SSID is correct, make sure to enter the correct password and try again.

If your problems persist, see your documentation for help and networking tips.

Checked Items

Wireless Network Name (SSID) Check	FAIL
Communication Mode Check	Unchecked
Security Mode Check	Unchecked
MAC Address Filtering Check	Unchecked
Security Key/Password Check	Unchecked
IP Address Check	Unchecked
Detailed IP Setup Check	Unchecked

Network Status

Printer Name	EPSON XXXXXX
Printer Model	XX-XXX Series
IP Address	169.254.137.8
Subnet Mask	255.255.0.0
Default Gateway	
Network Name (SSID)	EpsonNet
Security	None
Signal Strength	Poor
MAC Address	F8:D0:27:40:C0:AC

a. Алдааны код

b. Сүлжээний орчин дахь мэдээлэл

Холбогдох мэдээлэл

- ➔ 70 хуудас дээрх "E-1"
- ➔ 70 хуудас дээрх "E-2, E-3, E-7"
- ➔ 71 хуудас дээрх "E-5"
- ➔ 71 хуудас дээрх "E-6"
- ➔ 71 хуудас дээрх "E-8"
- ➔ 72 хуудас дээрх "E-9"
- ➔ 72 хуудас дээрх "E-10"
- ➔ 73 хуудас дээрх "E-11"
- ➔ 73 хуудас дээрх "E-12"
- ➔ 73 хуудас дээрх "E-13"
- ➔ 74 хуудас дээрх "Сүлжээний Орчин дахь Зурвас"

Сүлжээний тохиргоо

E-1

Шийдлүүд:

- ☐ Таны принтер болон таны хаб болон бусад сүлжээний төхөөрөмжүүдэд Этернэтийн кабел холбогдсон эсэхийг шалга.
- ☐ Хаб болон бусад сүлжээний төхөөрөмжүүд асаалттай эсэхийг шалга.
- ☐ Принтерээ Wi-Fi-р холбохыг хүсвэл, идэвхигүй болсон учраас принтерийн Wi-Fi тохиргоог дахин тохируул.

E-2, E-3, E-7

Шийдлүүд:

- ☐ Таны утасгүй рүүтэр асаалттай эсэхийг шалга.
- ☐ Таны компьютер юмуу төхөөрөмж утасгүй рүүтэртэй зөв холбогдсон эсэхийг баталгаажуул.
- ☐ Утасгүй рүүтэрийг унтраа. 10 орчим секунд хүлээгээд асаа.
- ☐ Принтерээ утасгүй рүүтэрт ойрхон тавиад тэдгээрийн хоорондын саадыг арилгана.
- ☐ Хэрэв та SSID-г гар аргаар оруулсан бол зөв оруулсан эсэхээ шалга. SSID-г сүлжээний холболтын тайлангийн **Network Status** хэсгийг шалга.
- ☐ Хэрвээ утасгүй рүүтэр олон SSID-тэй бол харагдсан SSID-г сонго. SSID үл тохирох давтамжийг ашиглаж байгаа бол принтер түүнийг харуулахгүй.
- ☐ Сүлжээний холболтыг үүсгэхэд түлхэх товчлуурын тохиргоог ашиглаж байгаа бол таны утасгүй рүүтэр WPS дэмждэг эсэхийг шалга. Хэрвээ таны утасгүй рүүтэр WPS дэмждэггүй бол түлхэх товчлуурын тохиргоог ашиглаж болохгүй.
- ☐ Таны SSID зөвхөн ASCII тэмдэгтүүдийг (үсэг тоон тэмдэгт болон тэмдэгүүд) ашиглаж байгаа эсэхийг шалга. ASCII тэмдэгтүүдээс өөр ямар нэг тэмдэгт агуулсан SSID-г принтер харуулах боломжгүй.
- ☐ Утагүй рүүтэрт холбохоос өмнө SSID болон нууц үгээ мэдэж байгаа эсэхийг шалга. Хэрэв та утасгүй рүүтэрийг өгөгдмөл тохиргоогоор нь хэрэглэж байгаа бол SSID болон нууц үг утасгүй рүүтэрийн шошгон дээр бичигдсэн байх болно. Хэрэв та SSID болон нууц үгийг мэдэхгүй бол утасгүй рүүтэр тохируулсан хүнтэй холбогдох буюу утасгүй рүүтэртэй хамт ирсэн бичиг баримтыг үзээрэй.
- ☐ Хэрэв та ухаалаг төхөөрөмжийн тетеринг функц ашиглан үүсгэсэн SSID руу холбогдохыг хүсвэл, ухаалаг төхөөрөмжтэй дагалдаж ирсэн бичиг баримт дээрх SSID болон нууц үгийг шалгана уу.
- ☐ Хэрэв Wi-Fi холболт гэнэт салгагдсан бол, дараах нөхцлийг шалгана уу. Хэрвээ эдгээр нөхцлүүдийн аль нэг тохирох бол дараах вебсайтаас програм татаж ажиллуулахаар өөрийн сүлжээний тохиргоог тэглээрэй.
<http://epson.sn> > **Тохируулга**
 - ☐ Өөр нэг ухаалаг төхөөрөмж товчлуурын тохируулгыг ашиглан сүлжээнд нэмэгдлээ.
 - ☐ Wi-Fi сүлжээ нь товчлуурын тохируулгаас өөр аргаар тохируулагдсан байна.

Холбогдох мэдээлэл

➔ [51 хуудас дээрх "Компьютертай холбогдох"](#)

Сүлжээний тохиргоо

➔ 61 хуудас дээрх "Принтерээс Wi-Fi тохиргоог хийх"

E-5

Шийдлүүд:

Утасгүй рүүтэрийн аюулгүй байдлын төрөл нь дараах зүйлүүдийн аль энд тохируулагдсан эсэхийг магадла. Хэрэв үгүй бол утасгүй рүүтэрийн аюулгүй байдлын төрлийг солин, принтерийн сүлжээний тохиргоог ресет хий.

- ☐ WEP-64 бит (40 бит)
- ☐ WEP-128 бит (104 бит)
- ☐ WPA PSK (TKIP/AES)*
- ☐ WPA2 PSK (TKIP/AES)*
- ☐ WPA (TKIP/AES)
- ☐ WPA2 (TKIP/AES)

* WPA PSK нь мөн WPA Хувийн гэж бас нэрлэгдэнэ. WPA2 PSK нь мөн WPA2 Хувийн гэж бас нэрлэгдэнэ.

E-6

Шийдлүүд:

- ☐ MAC хаяг шүүлт хүчингүй болсон эсэхийг шалга. Хэрэв хүчинтэй байвал, шүүлтэнд оруулахгүйн тулд принтерийн MAC хаягийг бүртгүүл. Дэлгэрэнгүйг утасгүй рүүтэрийг дагалдаж ирсэн гарын авлагаас лавлана уу. Та принтерийн MAC хаягийг сүлжээний холболтын тайлан дээрх **Network Status** хэсгээс шалгах боломжтой.
- ☐ Хэрвээ таны утасгүй рүүтэр WEP хамгаалалттай нэг баталгаажуулалт ашиглаж байгаа бол баталгаажуулалтын түлхүүр болон индекс зөв эсэхийг шалга.
- ☐ Утасгүй рүүтэр дээрх холбогдох төхөөрөмжийн тоо таны холбогдохыг хүссэн сүлжээний төхөөрөмжийн тооноос цөөн бол холбогдох төхөөрөмжүүдийн тоог нэмэхийн тулд утасгүй рүүтэр дээр тохиргоо хийнэ үү. Дэлгэрэнгүйг утасгүй рүүтэрийг дагалдаж ирсэн гарын авлагаас харна уу.

Холбогдох мэдээлэл

- ➔ 65 хуудас дээрх "Сүлжээний ахисан түвшний тохиргоо хийх"
- ➔ 74 хуудас дээрх "Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэх"

E-8

Шийдлүүд:

- ☐ Принтерийн IP Хаяг Авах нь **Автомат** дээр тохируулагдсан үед, утасгүй рүүтэр дээрх DHCP-ийг идэвхжүүл.
- ☐ Хэрэв принтерийн IP Хаяг Авах нь Гар аргаар дээр тохируулагдсан бол таны гар аргаар тохируулсан IP хаяг хязгаараас хэтэрсэн (жишээ нь: 0.0.0.0) тул хаагдана. Хүчинтэй IP хаягийг принтерийн хянах самбар буюу Web Configдээр тохируул.

Сүлжээний тохиргоо

Холбогдох мэдээлэл

➔ 65 хуудас дээрх "Сүлжээний ахисан түвшний тохиргоо хийх"

E-9

Шийдлүүд:

Дараахийг шалгана уу.

- ☐ Төхөөрөмжүүд асаалттай эсэх.
- ☐ Та принтерт холбохыг хүссэн төхөөрөмж дээрээсээ интернэтэд хобогдох, ижил сүлжээнд дэх компьютер, сүлжээний төхөөрөмжүүдэд хандах боломжтой.

Дээрхийг баталгаажуулсны дараа таны принтер болон сүлжээний төхөөрөмжтэй холбогдохгүй бол утасгүй рүүтэрээ унтраа. 10 орчим секунд хүлээгээд асаа. Дараах вебсайтаас програм суулгагч татаж ажиллуулахаар өөрийн сүлжээний тохиргоог тэглээрэй.

<http://epson.sn> > **Тохируулга**

Холбогдох мэдээлэл

➔ 51 хуудас дээрх "Компьютертай холбогдох"

E-10

Шийдлүүд:

Дараахийг шалгана уу.

- ☐ Сүлжээн дэх бусад төхөөрөмжүүд асаалттай эсэх.
- ☐ Хэрэв та принтерийн IP Хаяг авахыг Гар аргаар дээр тохируулсан бол сүлжээний хаягууд (IP хаяг, сабнэт маск, өгөгдмөл гарц) нь зөв байна.

Хэрэв эдгээр нь буруу байвал сүлжээний хаягийг ресет хий. Та принтерийн IP хаяг, сабнэт маск болон өгөгдмөл гарцыг сүлжээний холболтын тайлан дээрх **Network Status** хэсгээс шалгах боломжтой.

Хэрэв DHCP идэвхжсэн бол IP Хаяг Авахыг **Автомат** дээр тохируул. Хэрвээ та IP хаягийг гар аргаар тохируулахыг хүсвэл принтерийн IP хаягийг **Network Status**-с сүлжээний холболтын тайлан дээрээс шалгаад сүлжээний тохиргооны дэлгэцэн дээрх Гар ажиллагааг сонго. Сабнэт маскийг [255.255.255.0] дээр тохируул.

Таны принтер болон сүлжээний төхөөрөмжтэй холбогдохгүй бол утасгүй рүүтэрээ унтраа. 10 орчим секунд хүлээгээд асаа.

Холбогдох мэдээлэл

➔ 65 хуудас дээрх "Сүлжээний ахисан түвшний тохиргоо хийх"

Сүлжээний тохиргоо

E-11

Шийдлүүд:

Дараахийг шалгана уу.

- ☐ TCP/IP Тохируулгыг Гар аргаар дээр тохируулсан үед өгөгдмөл гарцын хаяг зөв эсэх.
- ☐ Өгөгдмөл гарцаар тохируулсан төхөөрөмж асаалттай эсэх.

Өгөгдмөл гарцын зөв хаягийг тохируул. Та өгөгдмөл гарцын хаягийг сүлжээний холболтын тайлан дээрх **Network Status** хэсгээс шалгах боломжтой.

Холбогдох мэдээлэл

➔ 65 хуудас дээрх "Сүлжээний ахисан түвшний тохиргоо хийх"

E-12

Шийдлүүд:

Дараахийг шалгана уу.

- ☐ Сүлжээн дэх бусад төхөөрөмжүүд асаалттай эсэх.
- ☐ Хэрэв гар аргаар оруулсан бол сүлжээний хаягууд (IP хаяг, сабнэт маск, өгөгдмөл гарц) зөв эсэх.
- ☐ Бусад төхөөрөмжүүдийн сүлжээний хаягууд (сабнэт маск, өгөгдмөл гарц) ижилхэн эсэх.
- ☐ IP хаяг бусад төхөөрөмжүүдтэй зөрчилдөхгүй эсэх.

Дээрхийг баталгаажуулсны дараа таны принтер болон сүлжээний төхөөрөмжтэй холбогдохгүй бол дараах зүйлийг туршаарай.

- ☐ Утасгүй рүүтэрийг унтраа. 10 орчим секунд хүлээгээд асаа.
- ☐ Суулгагч ашиглан сүлжээний тохиргоог хий. Та үүнийг дараах вебсайтаас ажиллуулж болно.
<http://epson.sn> > **Тохируулга**
- ☐ WEP аюулгүй байдлын төрлийг ашиглаж байгаа хандалтын цэг (утасгүй рүүтэр) дээр хэд хэдэн нууц үг бүртгүүлэх боломжтой. Хэрэв хэд хэдэн нууц үг бүртгэгдсэн бол, хамгийн эхэнд бүртгэгдсэн нууц үг нь принтерт тохируулагдсан эсэхийг шалга.

Холбогдох мэдээлэл

- ➔ 65 хуудас дээрх "Сүлжээний ахисан түвшний тохиргоо хийх"
- ➔ 51 хуудас дээрх "Компьютертай холбогдох"

E-13

Шийдлүүд:

Дараахийг шалгана уу.

- ☐ Хандалтын цэг (утасгүй рүүтэр), хаб, рүүтэр зэрэг сүлжээний төхөөрөмжүүд асаалттай эсэх.

Сүлжээний тохиргоо

- ❑ Сүлжээний төхөөрөмжийн TCP/IP Тохируулга гар аргаар тохируулагдаагүй эсэх. (Хэрэв бусад сүлжээний төхөөрөмжүүдийн TCP/IP Тохируулга гар аргаар тохируулагдсан байхад, принтерийн TCP/IP Тохируулга автоматаар тохируулагдсан бол принтерийн сүлжээ нь бусад төхөөрөмжүүдийн сүлжээнээс ялгаатай болж магадгүй.)

Хэрэв дээрхийг шалгасны дараа ч ажиллахгүй хэвээр байвал дараахыг шалгана уу.

- ❑ Утасгүй рүүтэрийг унтраа. 10 орчим секунд хүлээгээд асаа.
- ❑ Суулгагчийг ашиглан принтертэй ижил сүлжээнд байгаа компьютер дээр сүлжээний тохиргоог хий. Та үүнийг дараах вебсайтаас ажиллуулж болно.

<http://epson.sn> > **Тохируулга**

- ❑ WEP аюулгүй байдлын төрлийг ашиглаж байгаа хандалтын цэг (утасгүй рүүтэр) дээр хэд хэдэн нууц үг бүртгүүлэх боломжтой. Хэрэв хэд хэдэн нууц үг бүртгэгдсэн бол, хамгийн эхэнд бүртгэгдсэн нууц үг нь принтерт тохируулагдсан эсэхийг шалга.

Холбогдох мэдээлэл

- ➔ 65 хуудас дээрх "Сүлжээний ахисан түвшний тохиргоо хийх"
- ➔ 51 хуудас дээрх "Компьютертай холбогдох"

Сүлжээний Орчин дахь Зурвас

Зурвас	Шийдэл
*Multiple network names (SSID) that match your entered network name (SSID) have been detected. Confirm network name (SSID).	Хэд хэдэн утасгүй рүүтэр дээр нэг ижил SSID тохируулах боломжтой. Утасгүй рүүтэрийн тохиргоог шалгаж, SSID-г өөрчил.
The Wi-Fi environment needs to be improved. Turn the wireless router off and then turn it on. If the connection does not improve, see the documentation for the wireless router.	Дундах саад болох зүйлсийг нь авч принтерийг хандалтын цэгт ойртуулсны дараа утасгүй рүүтэрийг унтраана уу. 10 орчим секунд хүлээгээд асаа. Хэрэв холбогдохгүй хэвээр байвал, утасгүй рүүтэртэй хамт ирсэн бичиг баримтыг үзээрэй.
*No more devices can be connected. Disconnect one of the connected devices if you want to add another one.	Зэрэг холбогдож болдог компьютер болон ухаалаг төхөөрөмжүүдийг Wi-Fi Direct (Энгийн AP) холболтоор иж бүрнээр нь холбож болно. Өөр төхөөрөмж юмуу ухаалаг төхөөрөмж нэмэхийн тулд холбогдсон төхөөрөмжийн нэгийг салгах хэрэгтэй. Сүлжээний төлөвийн хуудас юмуу принтерийн хянах самбарыг шалгаж зэрэг холбогдох утасгүй төхөөрөмжүүд болон холбогдсон төхөөрөмжийн тоог баталгаажуулж болно.
The same SSID as Wi-Fi Direct exists in the environment. Change the Wi-Fi Direct SSID if you cannot connect a smart device to the printer.	Принтерийн хянах самбар дээрээс Wi-Fi Direct Тохиргоо гэж ороод тохиргоог өөрчлөхийн тулд цэсийг сонго. Та DIRECT-XX-н дараа сүлжээний нэрийг өөрчилж болно. 32 тэмдэгтэд багтаан оруулна уу.

Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэх

Та үүнийг хэвлэж нарийн сүлжээний мэдээллийг шалгах боломжтой.

1. Цаасаа ачаална.

Сүлжээний тохиргоо

2. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.

3. **Принтерийн тохиргоо** > **Сүлжээний тохиргоо** > **Сүлжээний Статус**-г сонго.

4. **Төлөвийн Хуудсыг Хэвлэх**-ийг сонго.

5. Зурвасыг шалгаад сүлжээний төлөвийн хуудасыг хэвлэнэ.

6. Дэлгэцийг хаана.

Тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.

Шинэ утасгүй роутерийг солих, нэмэх

Утасгүй роутерийг сольсон, эсвэл утасгүй роутерийг нэмсэн, шинэ сүлжээний орчинг нэмснээс болж SSID өөрчлөгдсөн бол, Wi-Fi тохиргоогоо дахин тохируулна.

Холбогдох мэдээлэл

➔ [75 хуудас дээрх "Компьютерт холбох аргыг өөрчлөх"](#)

Компьютерт холбох аргыг өөрчлөх

Суулгагчийг ашиглан өөр холболтын аргыг шинээр тохируул.

- ☐ Вэбсайтаас тохируулах

Дараах вэбсайтаас нэвтэрч бүтээгдэхүүний нэрээ оруулна уу. **Тохируулга** орж, дараа нь суурилуулж эхэл.

<http://epson.sn>

- ☐ Программ хангамжийн диск ашиглан суулгах (зөвхөн диск драйвтай Windows компьютертой хэрэглэгч болон программ хангамжийн дисктэй загваруудад зориулагдсан)


Компьютерт программ хангамжийн дискийг оруулаад дэлгэцэн дээрх зааварчилгааг дага.

Холболтын аргуудын өөрчлөлтийг сонгох

Дараах дэлгэц гарч иртэл дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Сүлжээний тохиргоо

Принтер холболтыг дахин хий (шинэ сүлжээний рүүтэрийг юмуу USB-с сүлжээ рүү шилжих гэх мэт.)-г Програмыг суулгах дэлгэц дээр сонгож **Дараах** товш.



Хянах самбараас Сүлжээний тохиргоог Ethernet болгон өөрчлөх

Доорх алхамуудыг дагаж хянах самбар ашиглан Wi-Fi-с Ethernet болгон сүлжээний холболтыг өөрчил.

1. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.
Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.
2. **Принтерийн тохиргоо > Сүлжээний тохиргоо > Утастай LAN тохируулга**-г сонго.
3. OK товчийг дарна.
4. Принтерийг Ethernet кабель ашиглан роутертай холбоно.

Wi-Fi Direct (Энгийн AP) тохиргоог өөрчлөх

Хэрэв Wi-Fi Direct (Энгийн AP) холболт идэвхэжсэн бол, та тохиргоог **Wi-Fi > Wi-Fi Direct > Тохируулгыг эхлүүлэх > Солих**-с өөрчилж болох ба дараах цэс дээрх зүйлсийг харуулах болно.

Сүлжээний тохиргоо

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.

Сүлжээний нэрийг өөрчлөх (SSID)

Принтер лүү холбогдоход ашигладаг байсан Wi-Fi Direct (Энгийн AP) сүлжээний нэрийг (SSID), өөрийн сонгосон нэр болгон өөрчил. Та хяналтын самбарын програм хангамжийн гаран дээр гарч байгаа сүлжээний нэрийг (SSID) ASCII тэмдэгтүүдээр тохируулах боломжтой.

Сүлжээний нэрийг (SSID) өөрчлөх үед бүх холбогдсон төхөөрөмжүүд салгагдсан байна. Хэрэв та төхөөрөмжийг дахин холбохыг хүсвэл шинэ сүлжээний нэрийг (SSID) ашиглана уу.

Нууц үгийг өөрчлөх

Принтер лүү холбогдоход зориулсан Wi-Fi Direct (Энгийн AP) нууц үгийг өөрийн сонгосон утга болгон өөрчил. Та хяналтын самбарын програм хангамжийн гаран дээр гарч байгаа нууц үгийг ASCII тэмдэгтүүдээр тохируулах боломжтой.

Нууц үгийг өөрчлөх үед бүх холбогдсон төхөөрөмжүүд салгагдсан байна. Хэрэв та төхөөрөмжийг дахин холбохыг хүсвэл шинэ нууц үгийг ашиглана уу.

Wi-Fi Direct (Энгийн AP)-ийг салгах

Принтерийн Wi-Fi Direct (Энгийн AP) тохиргоог салга. Үүнийг салгах үед, принтер лүү Wi-Fi Direct (Энгийн AP) холболтоор холбогдсон бүх төхөөрөмжүүдийн холболт салгагдана.

Wi-Fi Direct (Энгийн AP) тохиргоог сэргээх

Бүх Wi-Fi Direct (Энгийн AP) тохиргоог өгөгдмөл болгон буцаана.

Принтерт хадгалагдсан ухаалаг төхөөрөмжийн Wi-Fi Direct (Энгийн AP) холболтын мэдээлэл нь устах болно.

Тэмдэглэл:

Мөн та дараах тохиргоог **Network** таб > *Web Config* дээрх **Wi-Fi Direct**-с тохируулж болно.

- ☐ Wi-Fi Direct (Энгийн AP)-ийг идэвхжүүлэх эсвэл салгах
- ☐ Сүлжээний нэрийг өөрчлөх (SSID)
- ☐ Нууц үгийг өөрчлөх
- ☐ Wi-Fi Direct (Энгийн AP) тохиргоог сэргээх


Хянах самбараас Wi-Fi-г салгах

Wi-Fi-г салгавал Wi-Fi холболт мөн сална.

Сүлжээний тохиргоо

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.



2. **Рүүтэр**-ийг сонго.
Сүлжээний статус харагдана.
3. **Тохиргоог өөрчлөх**-ийг сонго.
4. **Бусад** > **Wi-Fi-г хаах**-г сонгоно.
5. Зурвасыг шалгаад тохиргоог эхлүүлнэ.
6. Дууссан зурвас гарч ирвэл дэлгэцийг хаа.
Тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.
7. 🏠 товчлуурыг дарна.

Хянах самбараас Wi-Fi Direct (Энгийн AP) холболтыг салгах


Тэмдэглэл:

Wi-Fi Direct (Энгийн AP) холболтыг салгах үед, Wi-Fi Direct (Энгийн AP) холболтоор принтерт холбогдсон бүх компьютер ба ухаалаг төхөөрөмж сална. Хэрэв та тодорхой төхөөрөмжөөс холболтоо салгахыг хүсвэл принтер биш төхөөрөмжөө салгана уу.

Сүлжээний тохиргоо

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.



2. **Wi-Fi Direct**-ийг сонго.
Wi-Fi Direct мэдээлэл харагдана.
3. OK товчийг дарна уу.
4. **Солих**-ийг сонго.
5. **Wi-Fi Direct-г идэвхгүй болгох**-ийг сонго.
6. OK товчийг дарна уу.
7. Дууссан зурвас гарч ирвэл дэлгэцийг хаа.
Тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.
8. 🏠 товчлуурыг дарна.

Принтерийн хянах самбараас Сүлжээний тохиргоог сэргээх

Та сүлжээний бүх тохиргоог үндсэн хэлбэрт нь буцааж сэргээх боломжтой.

1. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.
Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.
2. **Принтерийн тохиргоо > Системийн Удирдлага > Өгөгдмөл тохиргоог сэргээх > Сүлжээний тохиргоо**-ийг сонго.
3. Мэдээллийг шалгаж, дараа нь **Тийм**-г сонгоно.

Сүлжээний тохиргоо

4. Дууссан зурвас гарч ирвэл дэлгэцийг хаа.

Тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.

ХЭВЛЭХ

Windows дээрх принтерийн драйвераас ХЭВЛЭХ

Принтерийн драйверийн сонголтыг өөрчилж чадахгүй бол, тэдгээрийн админ хязгаарлаж болно. Тусламж авах бол администратортаа хандана уу.

Принтерийн драйверт хандах

Компьютерийн хяналтын самбараас принтерийн драйверт хандаж байхдаа тохиргоо нь бүх програмд орсон байна.

Хяналтын самбараас принтерийн драйверт хандах

☐ Windows 10/Windows Server 2016

Эхлэл товч дээр дарж, **Windows Систем > Хяналтын самбар > Төхөөрөмж ба принтерийг харах-г Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарах эсвэл түүн дээр дарж байгаад **Хэвлэх тохиргоо**-г сонгоно.

☐ Windows 8.1/Windows 8/Windows Server 2012 R2/Windows Server 2012

Десктоп > Тохиргоо > Хяналтын самбар > Төхөөрөмж, принтер харах-г Техник хангамж ба дуу дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарах эсвэл түүн дээр дарж байгаад **Хэвлэх тохиргоо**-г сонгоно.

☐ Windows 7/Windows Server 2008 R2

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Техник хангамж, принтерийг харах-г Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж **Хэвлэх тохиргоо**-г сонгоно.

☐ Windows Vista/Windows Server 2008

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Принтер-г Техник хангамж ба дуу** дээрээс сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж **Хэвлэх тохиргоог сонгох**-г сонгоно.

☐ Windows XP/Windows Server 2003 R2/Windows Server 2003

Старт товч дээр дарж, **Хяналтын самбар > Принтер ба бусад Техник хангамж > Принтер ба Факс**-г сонгоно. Принтер дээрээ хулганы баруун товчийг дарж **Хэвлэх тохиргоо**-г сонгоно.

Ажлын мөрөн дээрх принтерийн тэмдгээс принтерийн драйверт хандах

Десктопын ажлын мөрөн дээрх принтерийн тэмдэг нь принтерийн драйверт хурдан хандах боломж олгох товчилбор тэмдэг юм.

Та принтерийн тэмдэг дээр дарж **Принтерийн Тохиргоо**-г сонговол, хяналтын самбараас дамжиж ордог принтерийн тохиргооны цонхтой ижил цонх руу хандах боломжтой. Хэрэв та энэхүү тэмдэг дээр хулганаа хоёр товшвол, та принтерийн төлөвийг шалгах боломжтой.

Хэвлэх

Тэмдэглэл:


Принтерийн тэмдэг ажлын мөр дээр харагдахгүй байвал, принтерийн драйверийн цонх руу орж **Ажиглалтын Тохируулгууд-г Арчилгаа** таб дээрээс дараад **Товчилбор тэмдэгийг taskбарт бүртгүүл-г** сонгоно.

Принтерийн үндсэн мэдээлэл

Тэмдэглэл:

Програмаас шалтгаалж үйлдлүүд нь ялгаатай байж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

1. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
Хэрвээ өмнө нь принтерт цаас ачаалаагүй бол ачаал.
2. **Хэвлэх** эсвэл **Цаасны Тохируулга-г Файл** цэснээс сонгоно.
3. Принтерээ сонгоно.
4. Принтерийн драйверын цонход хандахын тулд **Тохируулгууд** эсвэл **Шинж чанар-г** сонгоно уу.



5. Хэрэгтэй бол тохиргоог өөрчил.
Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл принтерийн цэсний сонголтыг харна уу.

Тэмдэглэл:

- ☐ Мөн тохиргооны хэсгүүдийн тайлбарыг онлайн тусламжаас харж болно. Хэсэг дээр хулганы баруун товчлуурыг дарахад **Тусламж** харагдана.
- ☐ **Хэвлэхээс өмнө харах-ийг** сонговол баримтыг хэвлэхийн өмнө урьдчилан харж болно.

6. Принтерийн драйверийн цонхыг хаахын тулд **ОК** дар.

Хэвлэх

7. Хэвлэх товчийг дар.

Тэмдэглэл:


Та **Хэвлэхээс өмнө харах**-ийг сонговол урьдчилан харах цонх гарч ирнэ. Тохиргоог өөрчлөхийн тулд **Цуцлах** дарж алхам 2-ын дүрмийг давтана.

Холбогдох мэдээлэл

- ➔ 25 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"
- ➔ 30 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 33 хуудас дээрх "Арын Цаасны Дайз руу цаас ачаалах"
- ➔ 36 хуудас дээрх "Цаасны төрлийн жагсаалт"
- ➔ 98 хуудас дээрх "Үндсэн таб"

2-талаар хэвлэх

Та цаасны хоёр талын алинд ч хэвлэж болно. Хэвлэсэн хуудсуудыг дахин шинэчлэн товхимол үүсгэн, хэвлэгдсэн хэсгийг эвхэн хэвлэх боломжтой.



Тэмдэглэл:

- ☐ Та автомат болон гараар хоёр талаар хэвлэхийг ашиглаж болно. Хоёр талыг гараар хэвлэх үед принтер эхний талыг хэвлэж дуусахад цаасыг нөгөө талаар эргүүлэн принтерт хийнэ.
- ☐ 2-талт хэвлэлтэнд тохиромжтой цаасыг ашиглахгүй бол, хэвлэлийн чанар муудаж, цаас гацалт үүсэх боломжтой.
- ☐ Цаас болон өгөгдлөөс шалтгаалж, бэх цаасны нөгөө тал руу нэвчиж магадгүй.

Холбогдох мэдээлэл

- ➔ 25 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"

Принтерийн тохиргоо

EPSON Status Monitor 3 идэвхжсэн тохиолдолд гар аргаар 2-талт хэвлэлтийг хийх боломжтой. Принтерт сүлжээгээр дамжиж ханддаг болон принтерийг хуваан хэрэглэдэг бол 2 талд нь хэвлэх боломжгүй болно.

Хэвлэх

Тэмдэглэл:

EPSON Status Monitor 3-г идэвхжүүлэхийн тулд **Өргөтгөсөн Тохиргоо-г Арчилгаа** табаас олж дараад, дараа нь **EPSON Status Monitor 3-г идэвхжүүл-г** сонго.

1. Принтерийн драйверийн **Үндсэн** таб дээр **2-талт Хэвлэлт**-н сонголтуудаас сонго.

2. **Settings**-г дарж зохих тохиргоог хийгээд **OK**-г дарна.

Хэрэгтэй бол **Хэвлэх Нягтшил**-д тохиргоог хийнэ. Та хоёр талаар хэвлэх гар тохиргоог сонговол уг тохиргоо хийгдэхгүй.

Тэмдэглэл:

☐ Нугалмал товхимол хэвлэх бол **Товхимол**-г сонгоно.

☐ **Хэвлэх Нягтшил**-г тохируулж байхдаа баримтын төрлөөс хамаараад принтерийн нягтаршлыг тохируулж болно.

☐ Баримтын Төрлийг Сонгох цонхон дахь **Хэвлэх Нягтшил Тааруулах** болон **Чанар** таб дахь **Үндсэн** дээр сонгосон сонголтуудын зохицолоос шалтгаалж хэвлэлт удаашрах боломжтой.

3. **Хэвлэх** товчийг дар.

Гар аргаар 2-талт хэвлэлтийг гүйцэтгэх үед эхний тал хэвлэгдэж дууссаны дараа компьютер дээр дэлгэгддэг цонх гарч ирнэ. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"

➔ 98 хуудас дээрх "Үндсэн таб"

Нэг хуудсан дээр хэд хэдэн хуудсыг хэвлэх

Та нэг хуудсан дээр 2 эсвэл 4 хуудас мэдээллийг хэвлэх боломжтой.

**Хэвлэлтийн тохиргоо**

Принтерийн драйверын **Үндсэн** таб дээрх, **2-дээшээ** ба **4-дээшээ**-г **Олон-Хуудаст** тохиргоогоор сонгоно уу.


Хэвлэх

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 98 хуудас дээрх "Үндсэн таб"

Хуудсыг дараалалтай хэвлэх болон багцлах (Хэвлэх дарааллыг хөрвүүлэх)

Та хамгийн сүүлийн хуудаснаас эхлэн хэвлэснээр баримтууд хуудсын дараалалд орон багцлагдсан байна.



Хэвлэлтийн тохиргоо

Принтерийн драйверын **Үндсэн** таб дээрээс **Урвуу Дараалал**-г сонгоно уу.

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 98 хуудас дээрх "Үндсэн таб"

Жижигрүүлсэн эсвэл томруулсан баримт бичгийг хэвлэх

Та бичиг баримтын хэмжээг тодорхой хувиар бууруулж эсвэл нэмэгдүүлж болох ба принтерт ачаалсан цаасны хэмжээг тааруулна уу.



Принтерийн тохиргоо

Принтерийн драйвер дээрх **Илүү Сонголтууд** таб, **Баримтын Хэмжээ** тохиргооноос баримтын хэмжээг сонгоно. **Гаралтын Цаас** тохиргооноос хэвлэхийг хүсвэл цаасны хэмжээг сонгоно. **Баримтыг Багасгах/Томсгох**-г сонгосны дараа **Хуудсанд Тааруулах** эсвэл **Хүртэл томсго**-г сонго. **Хүртэл томсго**-г сонголвол хувийг оруулна.


Цаасны голд зургийг хэвлэх бол **Төв** -г сонгоно.

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 99 хуудас дээрх "Илүү Сонголтууд таб"

Томруулахын тулд олон хуудсан дээр нэг зураг хэвлэх (Зурагт хуудас хийх)

Энэ тохиргоо нь танд, нэг зургийг олон хуудас цаасан дээр хэвлэх боломжийг олгоно. Хэвлэсэн хэсгүүдээ нийлүүлэн нааж илүү том зурагт хуудас үүсгэх боломжтой.



Принтерийн тохиргоо


Принтерийн драйверын **Үндсэн** таб дээрээс, **2x1 Плакат**, **2x2 Плакат**, **3x3 Плакат**, **4x4 Плакат**-г **Олон-Хуудаст** тохиргоогоор сонгоно уу. Хэрэв та **Тохиргоо** товшвол, та хэвлэхийг хүсэхгүй байгаа самбаруудыг сонгох боломжтой. Та тайралтын хөтөч сонголтыг сонгож мөн болно.

Холбогдох мэдээлэл


- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 98 хуудас дээрх "Үндсэн таб"

Давхардсан Зэрэгцүүлэлтын Тэмдэг ашиглан зурагт хуудас хийх

2x2 Плакат-г сонгосон үед, **Давхардсан Зэрэгцүүлэлтын Тэмдэг**-г **Таслах Зураас Хэвлэх** дээр сонгосон байхад зурагт хуудсыг хэрхэн хийх жишээг доор харуулав.




1. Sheet 1 ба Sheet 2-г бэлтгэнэ. Sheet 1-н хүрээг цэнхэр босоо шугамын дагуу хайчилж, дээд болон доод хөндлөн тэмдгийн голоор дайруулан зүснэ.




Хэвлэх

2. Sheet 1-н ирмэгийг Sheet 2-н дээд талд байрлуулж, хөндлөн тэмдгийг тааруулна. Дараа нь, хоёр хуудсыг ар талаар нь нийлүүлж түр наалтаар наана.




3. Тохируулсан тэмдэглэлийн дагуу татсан босоо улаан шугамаар наасан хуудсыг хуваана (энэ удаад хөндлөн тэмдэглэгээний зүүн талын шугам).




Хэвлэх

4. Хуудсуудыг ар талаар нь наана.




5. Sheet 3 болон Sheet 4-г наахад 1-4-р алхмыг давтана.
6. Зүүн болон баруун талын хөндлөн тэмдэглэгээний дундуур татсан хөндлөн хөх шугамаар Sheet 1 болон Sheet 2-н хүрээг тайрна.




Хэвлэх

7. Sheet 1 болон Sheet 2 ирмэгийг Sheet 3 болон Sheet 4-н орой дээр байрлуулж, хөндлөн тэмдгийг тааруулан, дараа нь тэдгээрийг ар талаар нь түр наана.




Хэвлэх


8. Тохируулсан тэмдэглэгээний дундуур татсан улаан шугамын дагуу наасан хуудсыг хоёр хуваана (энэ удаад хөндлөн тэмдэгийн дээрх шугамаар).



9. Хуудсуудыг ар талаар нь наана.




10. Гаднах тэмдгийн дагуу үлдсэн хүрээг тайрна.



Толгой ба доод хэсгийг хэвлэх

Та хэрэглэгчийн нэр, хэвлэсэн огноо зэрэг мэдээллийг толгой, доод хэсэгт хэвлэх боломжтой.



Принтерийн тохиргоо

Принтерийн драйверийн **Илүү Сонголтууд** таб дээрээс **Усан тэмдгийн Үзүүлэлтүүд**-г дараад дараа нь **Дээд хэсэг/Доод хэсэг**-г сонго. **Тохиргоо**-г дараад дараа нь хэвлэхийг хүссэн зүйлээ сонго.

Хэвлэх

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 99 хуудас дээрх "Илүү Сонголтууд таб"

Хуулбарлалтын эсрэг хээ хэвлэх

Та хэвлэмэл материал дээрээ хуулбарлалтын эсрэг хээ хэвлэх боломжтой. Хэвлэх үед үсгүүд хэвлэгддэггүй бөгөөд хэвлэлт тэр чигтээ дэлгэцийн өнгөөр хөнгөн будагддаг. Эх хувийг хуулбараас амархан ялгахын тулд хуулбарлахад далд үсэг гарч ирдэг.



Хувилахын эсрэг Хээ нь дараах нөхцөлүүдэд боломжтой:

- ☐ Цаас: Хоосон цаас, Хуулбар цаас, Албан бичиг, Дахин боловсруулсан цаас, Өнгөтэй цаас, Урьдчилан хэвлэсэн цаас, Сайн чанартай хоосон цаас
- ☐ Чанар: Стандарт
- ☐ Автомат 2-талт хэвлэлт: сонгоогүй
- ☐ Өнгө Засалт: Автомат

Тэмдэглэл:

Та мөн өөрийн хуулбарлалтын эсрэг хээг нэмэх боломжтой.

Принтерийн тохиргоо


Принтерийн драйверийн **Илүү Сонголтууд** таб дээрээс **Усан тэмдгийн Үзүүлэлтүүд**-г дараад дараа нь Хувилахын эсрэг Хээ-г сонго. Хээний хэмжээ эсвэл нягтрал зэрэг дэлгэрэнгүй тохиргоог өөрчлөхийн тулд **Тохиргоо**-г дарна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 99 хуудас дээрх "Илүү Сонголтууд таб"

Нууц үгийн хамгаалалттай файлуудыг хэвлэх

Та принтерийн хянах самбарт нууц үг оруулсаны дараа хэвлэхийн тулд хэвлэх ажлын нууц үгийг тохируулах боломжтой.



Принтерийн тохиргоо

принтерийн драйверын **Илүү Сонголтууд** таб дээрээс, **Нууцлалтай Ажил** сонгож, дараа нь нууц үг оруулна уу.


Ажил хэвлэхийн тулд принтерийн хянах самбарын үндсэн дэлгэц дээрх **Нууцлалтай Ажил** сонгоно уу. Хэвлэхийг хүссэн ажлыг сонгож, дараа нь нууц үгийг оруулна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 99 хуудас дээрх "Илүү Сонголтууд таб"

Олон файлыг хамт хэвлэх

Ажил Эмхлэгч Лайт нь өөр өөр программ хангамжийн тусламжтай бүтээсэн хэд хэдэн файлыг нэгтгэж нэг хэвлэх ажил болгон хэвлэх боломжийг олгоно. Та нэгтгэсэн файлын хувьд тухайлбал олон хуудаст бүдүүвч, 2 талаар хэвлэх зэрэг хэвлэлтийн тохиргоог тодорхой зааж өгөх боломжтой.



Хэвлэх

Хэвлэлтийн тохиргоо

Принтерийн драйверын **Үндсэн** таб дээрээс **Ажил Эмхлэгч Лайт**-г сонгоно уу. Хэвлэж эхлэх үед Ажил Эмхлэгч Лайт цонх гарч ирнэ. Ажил Эмхлэгч Лайт цонх нээлттэй байхад, одоо ажиллаж буй файльтайгаа нэгтгэхийг хүсэж буй файлаа нээн, дээрх алхамыг давтан хий.

Таныг Ажил Эмхлэгч Лайт цонх дээрх, Прожектыг Хэвлэх руу нэмэгдсэн хэвлэх ажлыг сонгох үед хуудасны бүдүүвчийг засах боломжтой.

Хэвлэх гэснийг **Файл** цэсээс товшиж хэвлэж эхэлнэ үү.

Тэмдэглэл:

*Хэрэв та Ажил Эмхлэгч Лайт цонхыг бүх хэвлэх өгөгдлийг Прожектыг Хэвлэх руу нэмэхийн өмнө таны одоо ажиллаж байгаа хэвлэх ажил цуцлагдана. **Хадгалах** гэснийг **Файл** цэсээс товшиж одоогийн ажлыг хадгална уу. Хадгалсан файлын өргөтгөл нь "esl" байна.*


*Прожектыг Хэвлэх нээхийн тулд, принтерийн драйверын **Арчилгаа** таб дээрх **Ажил Эмхлэгч Лайт** дээр товшиж Ажил Эмхлэгч Лайт цонхыг нээнэ үү. Дараа нь, файлаа сонгохын тулд **Нээх**-г **Файл** цэснээс сонгоно.*

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 98 хуудас дээрх "Үндсэн таб"

Нийтлэг өнгө принтерийн онцлогийг ашиглан хэвлэх

Та хэвлэмэл текст болон зурагны харагдах байдлыг сайжруулж болно.



Өнгө Жигд Хэвлэлт нь зөвхөн дараах тохиргоо сонгогдсон үед боломжтой.

- ☐ Цаасны төрөл: Хоосон цаас, Хуулбар цаас, Албан бичиг, Дахин боловсруулсан цаас, Өнгөтэй цаас, Урьдчилан хэвлэсэн цаас, Сайн чанартай хоосон цаас
- ☐ Чанар: **Стандарт** эсвэл илүү өндөр чанартай
- ☐ Хэвлэх өнгө: **Өнгө**
- ☐ Програм: Microsoft® Office 2007 эсвэл түүнээс сүүлийн
- ☐ Текстийг хэмжээ: 96 pts эсвэл түүнээс жижиг

Хэвлэлтийн тохиргоо

Принтерийн драйверын **Илүү Сонголтууд** таб дээрээс, **Зургийн Сонголтууд** гэснийг **Өнгө Засалт** тохиргооноос товш. **Өнгө Жигд Хэвлэлт** тохиргооноос сонголтыг сонго. **Сайжруулалтын Сонголтууд** товшиж дараах тохиргоог хийнэ үү.

Хэвлэх

Тэмдэглэл:


- ☐ Тодорхой тэмдэгтүүдийг "±" гэж харагдах тухайлбал "+" ашиглан өөрчилж болно.
- ☐ Программын тодорхой хэв, доогуур зураас нь эдгээр тохиргоог ашиглан хэвлэгдсэн агуулгыг өөрчилж болно.
- ☐ Хэвлэлтийн чанар Өнгө Жигд Хэвлэлт тохиргоог ашиглах үед зураг болон бусад дүрс дээр буурах магадлалтай.
- ☐ Хэвлэлт нь Өнгө Жигд Хэвлэлт тохиргоог ашиглах үед удаан байна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 99 хуудас дээрх "Илүү Сонголтууд таб"

Принтерийн өнгийг тохируулах

Та хэвлэх ажилд хэрэглэж буй өнгийг тохируулах боломжтой.



Тэмдэглэл:

Эдгээр тохируулгыг үндсэн мэдээлэл дээр хийдэггүй.

Принтерийн тохиргоо

Принтерийн драйверын **Илүү Сонголтууд** таб дээр, **Өөрчлөх-г Өнгө Засалт** тохиргоогоор сонгоно уу. **Нэмэлт** товшиж **Өнгө Засалт** цонхыг нээгээд дараа нь өнгөний засварын аргыг сонго.

Тэмдэглэл:


- ☐ **Автомат** нь **Илүү Сонголтууд** таб дээр өгөгдмөлөөр сонгоно. Энэ тохиргоогоор, өнгө нь цаасны төрөл, хэвлэлтийн чанарын тохиргоотой нийцэж автоматаар тохируулагдана.
- ☐ **Өнгө Засалт** цонх дээрх **ФотоСайжрилт** нь гарчгийн байрлалыг задлан шинжилж өнгийг тохируулна. Тиймээс, та зургийг жижигрүүлж, томруулж, тайрч, эргүүлэн дүрсний байрлалыг өөрчилсөн бол, зурагны өнгө гэнэт өөрчлөгдөх магадлалтай. Хэрэв зураг фокусгүй болсон байвал, өнгө зохицол нь хэвийн бус болсон байх ёстой. Өнгө өөрчлөгдөж хэвийн бус болсон байвал **ФотоСайжрилт**-с өөр горимоор хэвлэнэ үү.

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 99 хуудас дээрх "Илүү Сонголтууд таб"

Нарийн зураасыг тодруулж хэвлэх

Та хэвлэхэд хэт нарийн зураасыг зузаан болгох боломжтой.



Хэвлэлтийн тохиргоо


Принтерийн драйверын **Илүү Сонголтууд** таб дээрээс, **Зургийн Сонголтууд** гэснийг **Өнгө Засалт** тохиргооноос товш. **Нарийн Шугамыг Тодруулах**-ийг сонго.

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 99 хуудас дээрх "Илүү Сонголтууд таб"

Бар кодыг тодорхой хэвлэх

Та бар кодыг тодорхой хэвлэж сканнердахад хялбар болгох боломжтой. Хэрэв таны хэвлэсэн бар код сканнердах боломжгүй бол үүнийг зөвхөн идэвхжүүл.



01234

Та дараах нөхцөлд энэ онцлог үйлчилгээг ашиглаж болно.

- ☐ Цаас: Ердийн цаас, Хувилах цаас, Захидлын толгой, Дахин боловсруулсан цаас, Өнгөт цаас, Урьдчилан хэвлэсэн цаас, Өндөр чанартай ердийн цаас, 91-ээс 256 г/м² зузаантай зузаан цаас, Epson Matte Paper-Heavyweight, Epson Double-Sided Matte Paper эсвэл дугтуй
- ☐ Чанар: **Стандарт, Өндөр** (161-ээс 256 г/м² зузаантай цаасанд, Epson Matte Paper-Heavyweight, болон Epson Double-Sided Matte Paper-д боломжгүй)

Тэмдэглэл:

Нөхцөл байдлаас шалтгаалж үргэлж тодосгох боломжгүй.

Хэвлэлтийн тохиргоо

Принтерийн драйверын **Арчилгаа** таб дээрээс **Өргөтгөсөн Тохиргоо** товшиж, дараа нь **Баркод Горим**-г сонгоно уу.

Хэвлэх

Холбогдох мэдээлэл

- ➔ 82 хуудас дээрх "Принтерийн үндсэн мэдээлэл"
- ➔ 100 хуудас дээрх "Арчилгаа таб"

Хэвлэхийг цуцлах

Та компьютероос хэвлэх ажлыг цуцлах боломжтой. Гэхдээ та хэвлэх ажил принтер рүү бүрэн илгээгдсэний дараа компьютероос хэвлэх ажлыг цуцлах боломжгүй. Энэхүү тохиолдолд, принтерийн хяналтын самбарыг ашиглан хэвлэх ажлыг цуцална.

Цуцлах

Компьютер дээрээсээ, **Төхөөрөмж ба принтерүүд, Принтер**, эсвэл **Принтер ба Факсууд** дээр байгаа өөрийн принтер дээр баруун товш. **Юу хэвлэж байгааг харах** товшиж, цуцлахыг хүсэж буй ажил дээр хулганы баруун товчийг дарж дараа нь **Цуцлах** товш.

Принтерийн драйверын цэсийн зүйлс

Программ дээрх хэвлэх цонхыг нээж, принтерийг сонгоод, дараа нь принтерийн драйверын цонхонд нэвтэрнэ үү.

Тэмдэглэл:

Таны сонгосон сонголтоос шалтгаалж цэсүүд янз бүр байна.

Үндсэн таб

Хэвлэлт Урьдчилж тохируул	Урьдчилсан тохиргоог Нэмэх/Хасах	Та өөрийн хүссэнээр олон дахин хэрэглэгддэг принтерийн тохиргоог нэмж хасаж болно. Хэрэглэхийг хүссэн тохируулгаа жагсаалтаас сонго.
Тохиргоог Харуулах	Үндсэн болон Илүү Сонголтууд таб дээр сүүлд суурилуулсан бүх зүйлийн жагсаалтыг харуулна.	
Өгөгдмөл утгыг Ресет хийх	Бүх тохиргоог үйлдвэрийн анхны утга руу буцаа. Илүү Сонголтууд таб дээрх тохиргоог мөн анхны утгад буцаана.	
Бэхний Түвшин	Бэхний түвшинг ойролцоогоор илэрхийлнэ.	
Цаасны Эх	Цаас орсон хэсгээс цаасны эх үүсвэрийг сонго. Автомат Сонголт сонгож принтерийн Цаасны тохиргоо дээрээс сонгогдсон цаасны эх үүсвэрийг автоматаар сонгоно уу.	
Баримтын Хэмжээ	Та хэвлэхийг хүссэн цаасны хэмжээг сонго. Хэрвээ та Хэрэглэгчийн Тодорхойлсон-г сонговол цаасны өргөн болон уртыг оруулна.	
Чиг	Хэвлэх үед ашиглахыг хүссэн байрлалыг сонгоно.	
Цаасны Төрөл	Хэвлэх цаасны төрлөө сонгоно.	
Чанар	Хэвлэх үед ашиглахыг хүссэн хэвлэх чанарыг сонгоно. Боломжтой тохиргоо нь таны сонгосон цаасны төрлөөс хамаарна.	
Өнгө	Хэвлэх ажлын өнгийг сонго.	

Хэвлэх

2-талт Хэвлэлт	Хоёр талтай хэвлэх үйлдлийг зөвшөөрдөг.	
	Settings	Та холбоотой ирмэг болон захыг тодорхойлох боломжтой. Олон хуудастай баримт хэвлэхдээ хуудасны өмнө эсвэл араас нь эхэлж хэвлэхээ сонгох боломжтой.
	Хэвлэх Нягтшил	Принтерийн нягтшилийг тохируулахын тулд баримтын төрлийн сонгоно. Хэрэв тохиромжтой хэвлэх нягтшил сонгогдсон бол та зургийг урвуу талаар урсаххаас сэргийлж чадна. Хэвлэх нягтшилыг гараар тохируулах бол User Defined -г сонгоно.
Олон-Хуудаст	Энэ нь нэг цаасан дээр олон хуудас эсвэл зурагт хуудас хэвлэх боломжийг нээнэ. Хэвлэгдсэн хуудсуудын дарааллыг тодруулах бол Хуудасны Дараалал -н дар.	
Copies	Хэвлэхийг хүссэн хуулбарын тоог тохируул.	
	Жиших	Олон хуудастай баримтыг багц багцаар нь багцалж, эрэмбэлэн хэвлэнэ.
	Урвуу Дараалал	Хамгийн сүүлийн хуудаснаас эхлэн хэвлэх ба ингэснээр хэвлэн гаргасны дараа хуудсууд зөв дараалалд орно.
Чимээгүй Горим	Принтерийн чимээг багасгана. Гэсэн хэдий ч, үүнийг идэвхжүүлэх нь хэвлэх хурдыг удаашруулж болно.	
Хэвлэхээс өмнө харах	Хэвлэхийн өмнө баримтыг урьдчилан харна.	
Ажил Эмхлэгч Лайт	Ажил Эмхлэгч Лайт тохиргоог ашиглан хэвлэхийг сонгоно.	

Илүү Сонголтууд таб

Хэвлэлт Урьдчилж тохируул	Урьдчилсан тохиргоог Нэмэх/Хасах	Та өөрийн хүссэнээр олон дахин хэрэглэгддэг принтерийн тохиргоог нэмж хасаж болно.Хэрэглэхийг хүссэн тохируулгаа жагсаалтаас сонго.
Тохиргоог Харуулах	Үндсэн болон Илүү Сонголтууд таб дээр сүүлд суурилуулсан бүх зүйлийн жагсаалтыг харуулна.	
Өгөгдмөл утгыг Ресет хийх	Бүх тохиргоог үйлдвэрийн анхны утга руу буцаа. Үндсэн таб дээрх тохиргоог мөн анхны утгад буцаана.	
Баримтын Хэмжээ	Баримтын хэмжээг сонго.	
Гаралтын Цаас	Та хэвлэхийг хүссэн цаасны хэмжээг сонго.Хэрвээ Гаралтын Цаас нь Баримтын Хэмжээ -ээс өөр байвал Баримтыг Багасгах/Томсгох нь автоматаар сонгогдоно.Баримтын хэмжээг солилгүй хэвлэж байгаа тохиолдолд Гаралтын Цаас -ийг сонгох шаардлагагүй.	
Баримтыг Багасгах/Томсгох	Баримтын хэмжээг томруулж багасгахыг зөвшөөрнө.	
	Хуудсанд Тааруулах	Гаралтын Цаас -д сонгогдсон цаасны хэмжээнд тааруулахын тулд баримтыг автоматаар томсгож багасгана.
	Хүртэл томсго	Тодорхой хувиар хэвлэнэ.
	Төв	Зургийг цаасны голд хэвлэнэ.

Хэвлэх

Өнгө Засалт	Автомат	Зургийн өнгийг автоматаар тохируулна.
	Өөрчлөх	Өнгийг гараар тохируулахыг зөвшөөрнө. Илүү тохиргоо хийх бол Нэмэлт -ийг товш.
	Зургийн Сонголтууд	Өнгө Жигд Хэвлэлт эсвэл Улаан-нүдийг засах зэрэг принтерийн чанарын сонголтыг идэвхүүлнэ. Мөн та нарийн шугамыг хэвлэлтэн дээр харагдахуйцаар өргөн болгож болно.
Усан тэмдгийн Үзүүлэлтүүд	Хуулбарын эсрэг эсвэл усан тэмдэглэгээ тохиргоо хийхийг зөвшөөрнө.	
Нууцлалтай Ажил	Хэвлэх үед нууц баримтуудыг нууц үгээр хамгаалах. Хэрвээ та энэ онцлогийг ашиглавал хэвлэх өгөгдөл принтерт хадгалагдаж зөвхөн принтерийн хяналтын самбарт нууц үгийг оруулсан тохиолдолд л хэвлэх боломжтой болно. Settings -ийг товшиж тохиргоог өөрчилнө үү.	
Нэмэлт Тохиргоо	180° Эргүүлэх	Хэвлэхийн өмнө цаасыг 180 градус эргүүлнэ. Энэ онцлог нь дугтуй зэрэг принтерт засагдсан чиглэлд ачаалдаг цаасан дээр хэвлэж байгаа үед хэрэгтэй.
	Өндөр Хурд	Хэвлэх толгой хоёр чиглэлд хөдлөх үед хэвлэнэ. Хэвлэх хурд илүү хурдан боловч, хэвлэлтийн чанар муудаж магадгүй.
	Толин Тусгал	Зургийг хөмөрснөөр толины тусгалын дүрслэлээр хэвлэгдэж гарна.


Арчилгаа таб

Хошуу Шалгах	Хэвлэх толгойн хошуу бөглөрсөн эсэхийг шалгаж хошууны шалгалтыг явуул.
Толгой Цэвэрлэх	Хэвлэх толгойн бөглөрсөн хошууг цэвэрлэнэ. Энэ онцлог нь тодорхой хэмжээний бэх ашиглах учраас зөвхөн хошуу нь бөглөрсөн тохиолдолд толгойг цэвэрлэ.
Ажил Эмхлэгч Лайт	Ажил Эмхлэгч Лайт цонхыг нээ. Та өгөгдлийг хадгалж, засварлаж болно.
EPSON Status Monitor 3	EPSON Status Monitor 3 цонхыг нээ. Та принтер эсвэл ажлын төлөвийг баталгаажуулах боломжтой.
Ажиглалтын Тохируулгууд	EPSON Status Monitor 3 цонхны зүйлүүдэд тохиргоо хийхийг зөвшөөрнө.
Өргөтгөсөн Тохиргоо	Олон төрлийн тохиргоо хийхийг зөвшөөрнө. Дэлгэрэнгүй мэдээллийг харах бол Тусламж гарах бүрт хулганы баруун товчийг дар.
Хэвлэх Дараалал	Хэвлэгдэхээр хүлээгдэж буй ажлуудыг харуулна. Та принтерийн ажлуудыг шалгаж, түр зогсоож эсвэл дахин эхлүүлж болно.
Принтер болон Сонголтын Мэдээлэл	Та хэрэглэгчийн бүртгэл бүртгүүлж болно. Хэрвээ нэвтрэх удирдлага принтер дээр суусан бол та аккаунтаа бүртгүүлэх шаардлагатай.
Хэл	Принтерийн драйверийн цонхонд ашиглагдах хэлийг солино. Тохиргоог хэрэглэхийн тулд принтерийн драйверийг хаагаад дахин нээнэ.
Програмын Шинэчлэл	Интернэт дэх програмын хамгийн сүүлийн үеийн хувилбарыг шалгахын тулд EPSON Software Updater-ийг эхлүүл.
Техникийн Дэмжлэг	Epson техникийн тусламжийн цахим хуудас руу нэвтрэхийг зөвшөөрнө.

Windows дээрх PostScript принтерийн драйвераас хэвлэх

PostScript принтерийн драйвер нь PostScript Хуудасны Тайлбар хэлийг ашиглан принтерт хэвлэх командыг өгдөг драйвер юм.

1. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
Хэрвээ өмнө нь принтерт цаас ачаалаагүй бол ачаал.
2. **Хэвлэх** эсвэл **Хэвлэх Тохируулга**-г **Файл** цэсээс сонгоно
3. Принтерээ сонгоно.
4. Принтерийн драйверын цонход хандахын тулд **Тохируулгууд** эсвэл **Шинж чанар**-г сонгоно уу.



5. Хэрэгтэй бол тохиргоог өөрчил.
Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл принтерийн цэсний сонголтыг харна уу.
6. **OK** товшиж дэлгэрэнгүй мэдээлэл бүхий принтерийн драйвераас хаана уу.
7. **Хэвлэх** товчийг дар.

Холбогдох мэдээлэл

- ➔ 25 хуудас дээрх "Бэлэн байгаа цаас ба багтаамж"
- ➔ 30 хуудас дээрх "Цаасан Кассет руу цаас ачаалах"
- ➔ 33 хуудас дээрх "Арын Цаасны Дайз руу цаас ачаалах"

Хэвлэх

- ➔ 36 хуудас дээрх "Цаасны төрлийн жагсаалт"
- ➔ 102 хуудас дээрх "Цаас/Чанарын таб"
- ➔ 102 хуудас дээрх "Бүдүүвч таб"

PostScript принтерийн драйверын цэсийн зүйлс

Программ дээрх хэвлэх цонхыг нээж, принтерийг сонгоод, дараа нь принтерийн драйверын цонхонд нэвтэрнэ үү.

Тэмдэглэл:

Таны сонгосон сонголтоос шалтгаалж цэсүүд янз бүр байна.

Цаас/Чанарын таб

Тэвш сонгох	Цаасны эх үүсвэр	Оруулсан цаасаас цаасны эх үүсвэрийг сонгоно уу. Автоматаар сонгох сонгож принтерийн Цаасны тохиргоо дээрээс сонгогдсон цаасны эх үүсвэрийг автоматаар сонгоно уу.
	Медиа	Хэвлэх цаасны төрлөө сонгоно.
Өнгө	Хэвлэх ажлын өнгийг сонгоно уу.	

Бүдүүвч таб

Чиглэл	Хэвлэх үед ашиглахыг хүссэн байрлалыг сонгоно.		
Хоёр талаар хэвлэх	Хоёр талтай хэвлэх үйлдлийг зөвшөөрдөг.		
Хуудсын дараалал	Дээд талаас эсвэл сүүлийн хуудсаас сонгож хэвлэх. Хэрэв та Урд тал руу буцах сонгосон бол хэвлэсэний дараа хуудасны дугаарт үндэслэн зөв дарааллаар хуудсуудыг багцлана.		
Хуудасны формат	Хуудас бүр дэх хуудсууд	Танд нэг хуудсан дээр хэд хэдэн хуудас хэвлэх боломж олгоно.	
		Хуудасны бүдүүвч бүрийн хуудсууд	Нэг хуудсан дээр хэд хэдэн хуудас хэвлэх үед хуудасны бүдүүвчийг тодорхой зааж өгөх боломж олгоно.
	Товхимол	Сонгож товхимол үүсгэнэ үү.	
		Товхимол нуруулдах	Товхимолын нуруулдах байрлалыг сонго.

Хандалт удирдах тохиргооны таб

Принтерийн хэрэглээ нь администратороор хязгаарлагдсан байж болно. Өөрийн бүртгэлээ принтерийн драйверт бүртгүүлсний дараа хэвлэх боломжтой. Хэрэглэгчийн бүртгэлийн дэлгэрэнгүйг администратортой холбогдож авна уу.

Хэвлэх

Хандалт удирдах тохиргоо	Хэрэглэгчийн бүртгэл	Танд хэрэглэгчийн нэр ба нууц үг оруулах боломж олгоно.
	Хэрэглэгчийн нэр	Хэрэглэгчийн нэрийг оруул.
	Нууц үг	Нууц үгийг оруул.

Нарийн сонголтууд

Цаас/гаралт	Цаасны хэмжээ	Та хэвлэхийг хүссэн цаасны хэмжээг сонго.	
	Хувь	Хэвлэхийг хүссэн хуулбарын тоог тохируул.	
График	Хэвлэх чанар	Хэвлэх үед ашиглахыг хүссэн хэвлэх чанарыг сонгоно.	
	Зургийн өнгөний зохицуулалт	ICM арга буюу санааг сонгох.	
	Хэмжилт	Бичиг баримтыг томруулж жижгэрүүлэх боломж олгоно.	
	TrueType үсгийн хэв	Үсгийн хэвийг TrueType болгон тохируул.	
Бичиг баримтын сонголтууд	Нарийн хэвлэлтийн онцлогууд	Хэвлэлтийн онцлогт нарийн тохиргоог хийх боломж олгоно.	
	PostScript сонголтууд	Сонголтын тохиргоог хийх боломж олгоно.	
	Принтерийн онцлогууд	Color Mode	Өнгөтөөр эсвэл нэг өнгөөр хэвлэх үү гэдгээ сонго.
		Press Simulation	Та офсет хэвлэлтийн CMYK бэхний өнгийг үүсгэж хэвлэх үедээ CMYK бэхний өнгийг дуурайхаар тохируулах боломжтой.
		Ink Save Mode	Хэвлэлтийн нягтралыг бууруулж бэхийг хэмнэнэ.
		Rotate by 180°	Хэвлэхийн өмнө өгөгдлийг 180 градус эргүүлнэ.

Хэвлэхийг цуцлах

Та компьютероос хэвлэх ажлыг цуцлах боломжтой. Гэхдээ та хэвлэх ажил принтер рүү бүрэн илгээгдсэний дараа компьютероос хэвлэх ажлыг цуцлах боломжгүй. Энэхүү тохиолдолд, принтерийн хяналтын самбарыг ашиглан хэвлэх ажлыг цуцална.

Цуцлах

Компьютер дээрээсээ, **Төхөөрөмж ба принтерүүд, Принтер**, эсвэл **Принтер ба Факсууд** дээр байгаа өөрийн принтер дээр баруун товш. **Юу хэвлэж байгааг харах** товшиж, цуцлахыг хүсэж буй ажил дээр хулганы баруун товчийг дарж дараа нь **Цуцлах** товш.

Mac OS дээрх принтерийн драйвераас хэвлэх

Хэвлэлтийн үндсэн мэдээлэл

Тэмдэглэл:

Програмаас шалтгаалж үйлдлүүд нь ялгаатай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг програмын тусламжаас үзнэ үү.

1. Хэвлэхийг хүссэн файлаа нээ.
Хэрэв өмнө ачаалаагүй бол принтерт цаасыг ачаал.
2. Хэвлэх харилцах цонход хандахын тулд **Хэвлэх**-ийг **Файл** цэс буюу өөр бусад удирдлагаас сонго.
Хэрэв шаардлагатай бол, **Дэлгэрэнгүйг Харуулах** эсвэл ▼-г дарж хэвлэх цонхыг томруул.
3. Принтерээ сонгоно.
4. Дэлгэгддэг цэснээс **Хэвлэх Тохиргоо**-г сонгоно.

The screenshot shows a print dialog box with the following settings:

- Printer: EPSON XXXX
- Presets: Default Settings
- Copies: 1
- Pages: ☒ All, ☐ From: 1 to: 1
- Paper Size: A4 (210 by 297 mm)
- Orientation: Portrait (indicated by a person icon)
- Print Settings: (expanded section showing)
 - Paper Source: Auto Select
 - Media Type: plain papers
 - Print Quality: Normal
 - ☐ Grayscale
 - ☐ Mirror Image

At the bottom are "Cancel" and "Print" buttons.

Хэвлэх

Тэмдэглэл:

OS X Mountain Lion болон дараагийн хувилбаруудад, **Хэвлэх Тохиргоо** цэс гарч ирэхгүй бол, Epson принтерийн драйвер зөв суулгагдаагүй байна гэсэн үг.

Системийн Тохируулгууд-г  цэс > **Принтер & Сканнер** (эсвэл **Хэвлэх & Сканнердах, Хэвлэх & Факсдах**)-аас сонгож, принтерийг устгаад дахин нэмнэ. Принтер нэмэх зааврыг дараахаас харна уу.

<http://epson.sn>

5. Шаардлагатай бол тохиргоог өөрчил.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд принтерийн драйверын цэсийн сонголтыг харна уу.


6. **Хэвлэх** товчийг дар.

Холбогдох мэдээлэл

